

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-32

1. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	5-13
2. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	13-20
3. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	20-21
4. Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудал	21-32

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 20 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Тэмүүжин;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Х.Баттулга, Л.Мөнхбаатар, М.Нарантуяа-Нара, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Энхбаяр.

Нэг. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, мөн зөвлөлийн гишүүн Л.Энхбилэг, Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа, мөн хорооны гишүүн Ц.Давхарбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Ганбат нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, П.Сайнзориг, Д.Ганбат нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10-т заасны дагуу санал хураалт болон хэлэлцүүлэгт оролцохгүй гэдгийг хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдсэн тул Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “эсрэг” гарсан саналыг түдгэлзсэнээр тооцов.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, мөн зөвлөлийн гишүүн Л.Энхбилэг, Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа, мөн хорооны гишүүн Ц.Давхарбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Энхцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Л.Соронзонболд, Х.Баасанжаргал, Д.Ганбат, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа нар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10-т заасны дагуу санал хураалт болон хэлэлцүүлэгт оролцохгүй гэдгийг хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдсэн тул Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “дэмжсэн” саналыг түдгэлзсэнээр тооцож, 53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга Т.Энхболд, мөн хэлтсийн албаны дарга Б.Баярсайхан, ахлах ажилтан Ц.Баасандэлгэр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Энхцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Ч.Сайнбилэг, С.Халиунаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нэр дэвшигчдийн талаар танилцуулав.

Нэр дэвшигчдээс болон сонсголын тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Д.Ганбат, П.Сайнзориг нарын тавьсан асуултад нэр дэвшигч Ч.Сайнбилэг, С.Халиунаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Х.Баасанжаргал, Да.Цогтбаатар, Б.Заяабал, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.6 дахь заалтын дагуу нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 1.Чимидийн Сайнбилэгийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Соронзонболдын Халиунааг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Жадамбаагийн Эрдэнэбилэгийг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 43 минут үргэлжилж, 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр 18 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим, 16 цаг 20 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан эхэлж байна. Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул, Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Хуралдааны ирц. Дамдины Цогтбаатар, Жуковын Алдаржавхлан, Хүрэлбаатарын Баасанжаргал, Батжаргалын Заяабал, Одсүрэнгийн Номинчимэг, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн ийм гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр, Ганбат гишүүн. Уучлаарай. Тэмдэглэгдээгүй би сая хараагүй байна шүү. Сая надад гэхдээ хэлсэн. Ганбат гишүүн бас ирж оролцож байгаа. Ингээд ирц 59,1 хувийн ирцтэйгээр хуралдаан эхэлж байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

2.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

3.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл,

4.Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайлан. Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байвал нэрсээ өгье. Алга байна. Тэгвэл ингээд хэлэлцэх асуудлыг баталсанд тооцлоо.

Ингээд асуудалдаа оръё. **1 дүгээр асуудал. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай”.**

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг уншиж танилцуулъя.

“Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай тогтоолын төсөл хүчингүй болсонд тооцох тухай”

1.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан саналаа холбогдох хуульд заасны дагуу ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж, санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасны дагуу, мөн Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдөр 01/1009 тоот, 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/2113 тоот хүсэлт уламжлах тухай, Шүүхийн сахилгын хорооноос Хууль зүйн байнгын хороонд 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 01/40 тоот, 2024 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 01/88 тоот хүсэлт уламжлах тухай албан бичиг ирүүлснийг тус тус үндэслэн Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлаас Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр баталсан бөгөөд уг хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг Ерөнхий зөвлөл шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг өөрийн батлагдсан төсвийн хүрээнд тогтоож, нэмэгдэл олгох журмыг батална гэж өөрчлөн найруулсан. Үүний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг тогтоох, олгох журам батлах тухай 2073 дугаар тогтоол, Шүүгчийн албан тушаалын цалин нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай 2274 дүгээр тогтоолыг тус тус баталсан.

Иймд хууль тогтоомжийн давхардал, хийдэл гаргахгүй байх зарчмын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2021 оны шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай Улсын Их Хурлын 2021 оны 4 дүгээр тогтоолыг хүчингүй болгох хэрэгцээ шаардлага байгаа тул, уг тогтоолын төслийг боловсруулсан болно.

Ингээд төслийг уншиж танилцууллаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүнийг нэмээд оруулъя. Ингээд Ганбат гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би яах вэ, зүгээр тогтоолтой шууд хамаатай биш боловч өнөөдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн удирдлагууд бас ирсэн байна. Уг нь Улсын Их Хурал болон Засгийн газраас тодорхой түвшинд бас шүүх эрх мэдлийг бэхжүүлэх бас нэг бие даасан эрх мэдэл утгаар нь бас дэмжлэгүүд, хууль, эрх зүйн шинэчлэлүүдийг цаг алдалгүй л хийж өгөөд байна л даа.

Тэгэхдээ зүгээр өнөөдөр шүүхийн үйлчилгээг иргэдэд хүргэх, шударга шүүхээр шүүлгэж, эргээд энэ 2 хүний хувийн маргаан нь бүр 2 туйлт байдал руугаа явахгүйгээр нийгмийн энэ итгэлцлийг тэр бага зөрчил дээр нь шийдээд, аль нэг маргааныг нь шийдээд өгөх энэ асуудал энэ анхан шатын шүүх дээр л байгаа юм л даа. Анхан шатын шүүхийн орон тоог энэ онд хэчнээнээр нэмэгдүүлээд байна. Би энэ дээр харин энэ чиглэл рүүгээ нэмэгдэл явахгүйгээр харин Нийслэлийн захиргааны давж заалдах шатын шүүх дээр 9 шүүгч нэмэх гэж байгаа байхгүй юу. Энэ ямар учиртай юм бэ. Ийм байдлаар явбал энэ цалин хөлсний нэмэгдлийг бас олгоход ч гэсэн хэцүү л байна. Яахаараа өнөөдөр жилдээ 60-хан хэрэг шийдэж байгаа. Би бол сошиал дээрээ 45-50 гэсэн. Сүүлийн статистикийг нь харсан. Жилд

1 шүүгч дээр 60 хэрэг оногдож байгаа Захиргааны давж заалдах шатын шүүгч дээр одоо 18 шүүгч байгаа дээр 9 шүүгч нэмж өгөх гээд байгаа юм.

Гэтэл энэ шүүхийн үйлчилгээ чинь анхан шат дээр маш урт очертой. Иргэд бухимдалтай. Ялангуяа иргэний шүүх дээр байнгын ачаалал өндөртэй ийм байж байхад ингээд Шүүхийн ерөнхий зөвлөл маань хэний эрх ашгаар хөтлөөд байна. Ийм зүйл байх юм бол харин би заримдаа ингээд шүүхийн төлөө маш олон жил бас л чадахаараа хувь нэмрээ оруулаад явж байгаа юм. Бас энэ дээр жоохон гонсойгоод байна. Та хэд маань бас ингэж зохисгүй аашилмааргүй байна. Яагаад ямар ачаалал үүсээгүй байгаа газар дээр 9-өөр нь орон тоо нэмж өгч байгаа юм бэ.

Би зарим давж заалдах шатын шүүхийн орон тоог нэмж байгаа дээр би дэмжиж байгаа. Тэгэхдээ жилийн статистик нь ингэж гарч байгаа шүүх дээр 9 орон тоо нэмж байгаа. Энийгээ больчхооч. Больж болох уу. Энийгээ анхан шат руу хуваарилж болох уу. Энэ дээр нэг хариулт өгөөч.

Д.Цогтбаатар: Ингэе. 1 дүгээрт нөгөө ажлын хэсгээ би танилцуулаагүй байна. Хэлэлцүүлж байгаа асуудалтай холбогдуулаад байгаа ажлын хэсгээ танилцуулъя. Н.Мөнгөнцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Л.Энхбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Д.Ариунтуяа Сахилгын хорооны дарга, Д.Эрдэнэтулга Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Ц.Давхарбаяр Шүүхийн сахилгын хорооны дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Яах вэ, асуулт бол шууд нээрээ одоо хэлэлцэх асуудалтай холбоотой бол асуудал биш байна. Дам утгаараа гэхдээ холбоотой гэж үзэж болно. Тийм учраас би хариулт өгөх нь зүйтэй гэж бодож байна. Ажлын хэсэг 3 дугаар микрофон хариулах уу. Хэн хариулах вэ. 5 дугаар микрофон Энхбилэг дарга.

Л.Энхбилэг: Гишүүддээ шинэ оны мэнд, энэ өдрийн мэнд хүргэе. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Шүүгчийн орон тоог бол Улсын Их Хурлаас тогтоож өгдөг. 2016 оны 42 дугаар тогтоолоор Нийслэлийн захиргааны анхан шатын шүүх дээр бол 16 шүүгчийн орон тоотой байсан. Сая 2024 онд Шүүх байгуулах тухай хуультай холбогдуулаад Улсын Их Хурлын 53 дугаар тогтоол гарсан. Үүгээр Захиргааны хэргийн анхан шатын шүүх, Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатын шүүх бол 27 шүүгчтэй байна гэж Улсын Их Хурал тогтоож өгсөн. Тогтоолоороо. Энэ тоо өөрөө судалгаатай. Өөрөөр хэлбэл Шүүх байгуулах тухай хуультай холбогдуулж Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх байгуулахад 34 шалгуур үзүүлэлтээр судалгаа хийсэн юм. Энэ тоогоор шүүгчийн хэрэг шийдвэрлэж байгаа тоогоороо 27 шүүгч ажиллавал зохист ачаалалтай ажиллана гэж гарсан юм. Тэгээд энэ зохист ачааллаар ажиллуулахын тулд бид нар сая шүүгчийн сонгон шалгаруулалтаар дутуу байгаа орон тоо буюу 53 дугаар тогтоолоороо 9 шүүгчийн орон тоонд сонгон шалгаруулалт зарласан юм.

Давж заалдах дээр мөн ялгаа байхгүй. Давж заалдах дээр мөн ачааллын судалгаагаа харж байгаад нэн ялангуяа давж заалдах бол нийт Монгол Улсад бол захиргааны анхан шатаар шийдсэн бүх хэргийг бол давж заалдах шатын шүүх нэгээрээ хянадаг. Давж заалдах шатны шүүх давхар бас нөгөө анхан шатын журмаар хэрэг маргаан шийдвэрлэж байгаа. Өөрөөр хэлбэл анхан шатаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан гомдлыг бас хэлэлцдэг. Дээр нь

богино хугацаанд шийдвэрлэх анхан шатын тендер гэх мэтчилний холбоотой богино хугацаанд шийдвэрлэдэг хэргүүдийг шийдвэрлэдэг. Монгол Улсад анхан шатаар шийдсэн бүх хэргүүд дээр давж заалдах журмаа шийддэг учраас ачааллынх нь хувьд судалгаагаа үндэслэж байгаад бид нар судалгаатайгаар орон тоогоо гүйцээж сонгон шалгаруулалтаа зарлахаар 9 гэж тоо тавьсан байгаа.

Д.Цогтбаатар: Тодруулъя Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Энхбилиг дарга аа, хэдүүлээ бас зөв мэдээлэл өгөөрэй. Анхан шатын шүүх дээр нэмж байгаа юмыг би ерөөсөө буруутгаагүй. Давж заалдах шат буюу захиргааны давж заалдах шатын шүүх дээр жилд 60 хэрэг шийдэж байгаа 1 шүүгч тэр шүү. Яагаад 9-ийг нэмж өгч байгаа юм бэ. Тийм ачаалал байхгүй байгаа шүү. Бүх анхан шатны журмаар шийдсэн маргааныг давж заалдах шатны шүүх хянадаггүй юм. Та ингээд худлаа хэлж, барин тавин шууд ингэж худлаа хэлж болохгүй. Энд бас Хууль зүйн байнгын хорооны гишүүд байгаа. Тэгэхээр ийм зохисгүй, энэ сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа болио. Наад 9 шүүгчийнхээ орон тоогоо өөр одоо эрүү, иргэний давж заалдах шатны шүүхүүдэд хуваарил. Ингэтлээ захиргааны давж заалдах шатны шүүх бас тийм өдөр шөнөгүй бүр ингэж үс ноосоо унатал ажиллаад байгаа зүйл байхгүй шүү. Ийм зүй зохистой байдлыг та хэд л хамгаалж, Шүүхийн ерөнхий зөвлөл хараат бусаар ажиллах ёстой байтал ийм сонин байдлаар яваад байх юм. Дараа нь яг яах вэ. Тоо худлаа хэлэхгүй шүү дээ. 1 шүүгч дээр 60 байгаа.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

Л.Энхбилэг: Тийм. Тоо худлаа хэлэхгүй л дээ. Би яг тоогоо л үндэслэж, нөгөө судалгаагаа үндэслэж л хариулаад байгаа юм. Ганц захиргааны давж заалдах шатны шүүх дээр орон тоо нэмээгүй. Орон нутаг дээр бид нар бүрэлдэхүүнгүй байсан. Давж заалдах шатны шүүх дээр зайлшгүй 3 шүүгч байж байж тэр хэрэг маргааныг шийдвэрлэнэ. Саяхныг хүртэл зарим орон нутаг дээр дандаа 2 давж заалдах шатны шүүгчтэй. Ойролцоох аймгуудаасаа томилолтоор буюу нүүдэллэн ажилладаг ийм байсан. Тэрийгээ бид нар сая бас бүрэлдэхүүнтэй болгохын тулд орон нутаг дээр ч гэсэн мөн адил тоо нэмсэн. Гишүүн ээ, би танд би яг нөгөө судалгаатай тоон мэдээллийг жич Зөвлөлийн даргатай ярьж байгаад хүргүүлье. Яг өнөөдрийн хувьд бол яг бэлтгэл жоохон муу ороод ирлээ.

Д.Цогтбаатар: Наад материал юмнуудаа нээрээ бэлтгээд Сайнзориг гишүүнд өг. Надад бас яг оруулж ирээд энэ Сайнзориг гишүүнийг намайг асуулаа гээд тооцоод, та нар бас тайлбараа өгөөрэй. Ганбат гишүүнд микрофон өгье.

Д.Ганбат: Энэ тогтоолын төсөлтэй танилцлаа. Хүмүүсийн хандлага гэдэг юм уу, зүйлүүд байна л даа. 10-аад жилийн өмнө бол Шүүх, шүүгчийн тухай хууль батлагдаад, тэгээд шүүгч нарын цалинг нэмж байсан. Тэр үед бол их гайхаж байсан. Яахаараа шүүгч нар цалин өндөр авах ёстой юм бэ гэж. Шүүх засаглал гэж байгаа шүү дээ. Хаана ч дэлхий даяар л тийм байдаг. Энэ ардчилсан улс орнууд. Хамгийн гэм буруутайг нь тогтоодог, ярьдаг хууль, ярьдаггүй хууль бол шүүх, ярьдаг хууль бол шүүгч гээд л байдаг л даа. Гэтэл энэ иймэрхүү юм байна. Одоо тэр хуулийн зүйл заалтад байгаа. Шүүх, шүүгч бол ямар нэгэн эдийн засгийн хамааралгүйгээр ажиллах тийм орчин боломжийг нь бүрдүүлсэн байх ёстой гэдэг хуулийн заалттай. Энэ хэвээрээ байгаа байлгүй дээ. Бид нарын үед батлаад, дэлхий нийтээрээ л тийм байдаг. Яг энэ шаардлагыг хангаж чадаж байгаа юу.

Өнөөдөр тухайн шүүгч хэн нэгэн хүний хараат бусаар тухайн асуудлыг, хэргийг шийдэх ийм боломж бололцоотой, хамгийн шилдэг хуульчид орж ажиллах ийм нөхцөл бололцоо энэ цалин дээр бүрдчихсэн байгаа юу. Шүүгч нар бол хэн нь ч давхар ажил эрхэлдэггүй шүү дээ. Ингээд энэ дээр бас нэг нэмэгдлүүд байгаа юм байна. Уг нь шүүгч бол ямар ч нэмэгдэлгүй цалин авдаг байсан. Одоо өөрчилж байгаа юм байна л даа. Доктор хэр олон байдаг юм танайд. Одоо танай системд чинь. Яг шүүгчийн цалин нэмснээс хойш бол тэр прокурор, АТГ гээд л хууль хяналтын байгууллагууд бүгд янз бүрийн нэмэгдлээр энийг хаагаад л бараг шүүгч нараас илүү цалин авдаг болчихсон байсан. Нөгөө шүүгч нарын юмыг болохоор бүгдээрээ буруу талаас нь тайлбарлаад л, ойлгохгүй ингэж явдаг байсан. Тэгээд энэ Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хороонд шүүгч бус гишүүд байгаа. Шүүгч тэндээс орж ажиллаж байгаа хүмүүсийг ойлгож байна. Тэд нар бол сонголт хийгээд орж ажиллаж байгаа байх. Эндээс томилогдсон хүмүүс яагаад яг тэр шүүгч нартайгаа адилхан цалин авах ёстой юм. Тэд нар бол яг тэр албан тушаалтан гэдгээрээ л авах ёстой шүү дээ. Арай ялгаатай. Би тэгж үзэж байна. Шүүхийн ерөнхий зөвлөл, энд байгаа хүмүүс юу гэж үздэг юм.

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг 4 хариулах уу. 5 дугаар микрофон. Энхбилэг дарга.

Л.Энхбилэг: Зөвлөлийн дарга зөвшөөрсөн учраас би хариулж байна. Ганбат гишүүний асуултад хариулъя. 2013 оноос хойш бол шүүгчийн цалин нэмэгдээгүй. 10-аад жил болсон. Сая хавар нийтээрээ 58 хувиар цалин нэмэгдсэн. Харьцангуй бас цалин нэмэгдсэнд шүүгч нар бол туйлын их талархалтай байгаа. Дээр нь сая хаврын чуулганаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, шүүгчийн цалинг Ерөнхий зөвлөл өөрийнхөө төсвийн хүрээндээ нэмэгдүүлэх тийм бүрэн эрхтэй болсон. Үүнийхээ дагуу бид нар 2024 оны 11 сарын 28-ны өдөр шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг тогтоох, олгох журмыг баталсан. Энэ журам дээрээ бол бид нар шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ бол шүүгч хараат бусаар ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх тэр нөхцөлийг бүрдүүлэх зарчим, шалгуур үзүүлэлт бүх юмаа бол тогтоож өгсөн. Одоо бол харьцангуй бас 2013 оноосоо хойш цалин нэмэгдчихсэн учраас бол тэр хэмжээндээ явж байна. Гэхдээ яг тэр амьжиргааных нь амьдрахад хүрэлцээтэй юу гэвэл бас хангалттай биш.

Яах вэ, тэр шүүгч онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан, Докторын гэсэн ийм 3 нэмэгдлүүдийг авч байгаа. Суурь цалин бол бид нар энэ журмаараа бол амьжиргааны баталгаажих доод түвшний хэмжээ, хөдөлмөрийн бүтээмжийн индекс, мөнгөний инфляц энэ тэр гээд бүх шалгуур үзүүлэлтээ харж байгаад бол тогтоож байгаа. Тэгэхээр харьцангуй бас тэр юм руу бол дөхүүлж хийхийг л хичээж л ажиллаж байна. Тэгэхдээ бас улс орны нөхцөл байдал ямар байгаа билээ. Төрийн албан хаагчдын авч байгаа цалин маань бас ямар билээ. Тэрийгээ бас дунджилж бас харж байгаа.

Докторын хувьд бол шүүхэд бол 10 орчим докторууд бол байна. Доктор шүүгч цөөхөн байдаг.

Д.Цогтбаатар: Тодруулъя. Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: За яах вэ, би нэг иймэрхүү л юм яриад байгаа юм л даа. Энэ Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо гэж байгаа. Тэнд чинь шүүгч бус гишүүд байгаа тийм үү. Тэр хүмүүс чинь яагаад цалингаа өсгөх ёстой юм бэ л

гэж би асуугаад байгаа юм. Шүүгч нарыг би шүүхийн хуулиар заалттай гээд байгаа. Угаасаа заалттай, хуулийн заалт байгаа. Тэгээд мөнгөний ханшийн уналт энэ тэр энэ бүх юмтай зэрэгцүүлээд үзэхэд тэр юмаа авч чадаж байгаа юу гэдэг нэг асуулт байгаа. Тэр доктор энэ тэр бол олон жил ажилласан энэ тэрээр авдаг л юм байгаа биз. Гол цаад санаа нь бол үйлчилгээ үзүүлж байгаа шүүхийн хэрэг шийдэж байгаа шүүгч бол бүгдээрээ л адилхан л хэрэг шийдээд тийм үйлчилгээ авч байна гэсэн ийм ойлголттой л байх ёстой шүү дээ ард түмэн бол. Тэгээд шүүх хараат бусаар ажиллах тэр боломжийг нь хангах ёстой. Яг тэр нь одоо хэдэн төгрөг байдаг юм, ямар байдаг юм, хангаж байгаа юу энэ тэр гээд би тодорхой асуултууд тавиад байна л даа.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. 3 дугаар микрофон өгье. Шүүхийн сахилгын хорооны дарга Ариунтуяа дарга.

Д.Ариунтуяа: Ганбат гишүүний асуултад хариулъя. 2021 оноос Сахилгын хороо бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж эхэлсэн. Мөн Ерөнхий зөвлөл ингээд томилогдоод бүрэн бүрэлдэхүүнээр ажиллаж эхлээд, Шүүхийн сахилгын хорооны даргад төрийн өндрийн 4, гишүүдийг бол төрийн өндрийн 5 зэрэг зиндааг ийм адилтгаж албан тушаалын зэрэглэлийг тогтоож өнөөдрийг хүрсэн. Үүнтэй холбогдуулаад 2023 оны 12 сарын 28-ны өдрийн Улсын Их Хурлын 117 дугаар тогтоолоор Сахилгын хороо болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг хяналтын шатны шүүхийн шүүгчтэй, харин гишүүдийг нь давж заалдах шатын Ерөнхий шүүгчдээ бол жишиг тогтоож, ингэж цалинг нь тогтоож өгсөн. Энэ нь юутай холбоотой вэ гэхээр Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь төрийн өндрийн 3, Шүүгчид нь бол төрийн өндрийн 4-д хамаардаг. Харин Сахилгын хорооны дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга бол яг хяналтын шатын шүүхийн шүүгчтэй ижилхэн төрийн өндрийн 4-д хамааруулдаг учраас шүүх эрх мэдлийн байгууллагуудыг 1 жишиг тогтоох үүднээс ингэж тогтоож ирсэн. Тэгэхээр саяын өнгөрсөн хаврын шүүхийн тухай хуулийн нэмэлтээр Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүгч нарынхаа цалинг өөрсдөө тогтоох ийм эрх хэмжээг авсантай холбогдуулаад тогтоосон. Үүний дагуу өөрчлөхөөр орж ирж байгаа.

Харин Шүүхийн сахилгын хороо болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг төрийн өндрийн 5-д хамаардаг. Гэхдээ бид бол хэдийгээр давж заалдах шатын шүүхийн ерөнхий шүүгч нь төрийн өндөрт хамаардаггүй ч гэсэн яах вэ жишгийг нь ингэж бууруулаад, Их Хурлын тогтоолоор батлаад явсан. Энэ дагуу явж байгаа. Ингээд тогтоолд өөрчлөлт оруулахаар оруулж ирж байгаа.

Д.Цогтбаатар: Энэ дээр зүгээр би нэг тодотгоод хэлэхэд, Ганбат гишүүн ээ бас нэг ийм ньюанс байгаа юм. Сая эд нар өөрсдөө гишүүдийг харахаараа та нар очоод уулзахаар ярьдаг юмаа ярихгүй юм. Цалинг тодорхой хэмжээгээр нэмж өгөхгүй бол байна шүү дээ сая би хөдөө, орон нутаг эд нараар явахад чинь шүүгчийн шалгалт зарлаад ирж орохгүй байгаа байхгүй юу. Ерөөсөө л бодит байдал чинь энэ. Эсвэл ирж орж байгаа хүн нь бүүр ерөөсөө шалгалтад тэнцэхгүй. Яадаг юм үзээд алдъя гэсэн хүмүүс орж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ажлыг чинь зах зээл дээр хүний сонирхлыг нь татахуйц болгохгүйн тулд эд нар өөрийн эрхгүй энийг тодорхой хэмжээнд нэмж өгөхгүй бол өнөөдрийн шүүхийн байгаа байдал маань байна.

Чадваргүй хүмүүс оччихсон байхад нарийн хүнд асуудлуудыг шийднэ гэх юм бол тэд нараас угаасаа тийм юм хүлээгээд хэрэггүй болчхож байгаа байхгүй юу. Нэг тийм бас ньуанс байж байгаа байх.

Нөгөө талаасаа яах вэ энэ чинь 2024 онд бидний л баталсан хуулийн дагуу эд нар тэр эрхийг нь шилжүүлээд, эд нар тэр хүрээндээ л хуулийнхаа хүрээнд бас юугаа гаргаад явж байгаа юм.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Энэ тушаал, тогтоолын хавсралттай ингээд хараад танилцаад явахаар нөгөө тоон дүн тавьчихсан байгаа нь яг үнэхээр анхаарал. Энэ дараагийнх нь уу. Одоо болохоор бид нар хүчингүй болох нь уу. Тэгвэл болилоо.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Өнөөдрийн хэлэлцэж байгаа энэ асуудлыг би бол дэмжинэ. Энийгээ би зүгээр хэлчихье. Тэгэхдээ хэдүүлээ нэг ийм зарчим тогтохгүй бол болохгүй нь ээ. Шүүхийн ерөнхий зөвлөл маань бас нэг жоохон бодоосой. Сая энэ хаврын чуулганаар бас том эрх мэдэл авангуутаа жоохон энийг буруугаар ашиглаж байна. Энийг Энхбаяр гишүүн бас ярьсан. Би одоо санал нэгдэж эхэлж байна. Төрийн алба сая цалингаа яах вэ 4 сард нэмээд, сая 1 сарын 1-ээс нэмж байгаа. Би ер нь бас ойр ойрхон нэмж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхдээ ингээд шүүгч нарын цалинг жилд 2 удаа нэмж болохгүй. Ингэж орон тоог гүйцээхгүй байж байгаад цалингаа угсраа нэмчхээд, дараа нь дахиад Сангийн яамаа шахаж байгаад явдаг ийм жишиг рүү ингээд орж байна. Яах вэ, ер нь зүгээр тэр тодорхой түвшинд нь аваачих ёстой гэдгийг ойлгож байна. Тэгэхээр бас төрийн албан дээр нийтлэг байдлаараа жилд 1 удаа нэмдэг, эсвэл тодорхой цаг үе, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалдаа тааруулж байгаад энэ шийдвэр энэ тэртэй бас жоохон уялдуулж явж бай. Яах вэ, яг таг гэж байгаа юм биш. Өөрсдөд нь шийдэх эрх нь байгаа. Тэгэхдээ төрийн албан хаагчдын цалинг сая 5 орчим хувиар нэмэгдүүлэхэд энэ орчимд л барьж байх ёстой. Сууриа анхнаасаа 6 хувиар тээ. Тэгэхээр энэ 6 хувиар нэмэгдүүлэхэд энэ хувиар. Тэгээд энийгээ нэг сууриа ерөнхий барьдаг. 6 дээр нэмэх нь бас тодорхой, дээш, доош хэдэн хувийн хэлбэлзэл бас байж болно. Ингэхгүй бол наад танай энэ систем төрийн албан хаагчдын нийтлэг байдлаараа яригдаж байна. Ингээд манай Шүүхийн ерөнхий зөвлөл энэ өөрт олгож байгаа эрх мэдлийг ингэж сонин байдлаар ашиглаад эхлэх юм бол явахгүй шүү. Наад энэ цалин тогтоодог шалгуур чинь үлдэж болох боловч жилд 1 удаа гэж хэлэх юм уу, ер нь цаашдаа бас анхаарахгүй бол болохгүй нь.

2 дугаарт надад бичгээр өгөөрэй. Яагаад Захиргааны давж заалдах шатын шүүх дээр ачаалалгүй шүүх дээр 9 орон тоо зарлаад, хэний эрх ашгийг хангах гээд байна. Энэ 9-ийн чинь цаана дахиад байшин сав, туслах, машин. Одоо боль. Тэрний хажууд анхан шатын шүүхэд өг. Эсвэл ачаалалтай байгаа аймгуудад иргэн, эрүүгийн шүүх дээр нь өгөөч ээ. Гуйж байна. Би шаардаж байна. Тэгэхгүй бол ингээд ачаалалгүй хэсэг дээр баахан мэдэхгүй байна. Ойлгохгүй байна. Та нар ингээд иргэн, захиргаа дээр ямар их ачаалал байгааг мэдэж байгаа шүү дээ. Өөрсдөө шүүгч байсан хүмүүс энд сууж байгаа шүү дээ. Шүүхэд нь ажиллаж байсан хүмүүс байгаа шүү дээ. Тэгээд би энэ дээр бас хатуу зарчим барина шүү.

Би энэ дээр харин ингэх юм бол тэр хаврын чуулганд хийсэн өөрчлөлтүүд дээр нь би ярина. Энхбаяр сайдын ярьж байгаа зарчим зөв байна лээ. Ингэж буруугаар ашиглаад байвал бас эргээд ярилцъя. Би энэ хаврын чуулганаар оруулсан өөрчлөлт дээр ажиллаагүй. Би тэгэхэд нийслэл дээр ажиллаж байсан учраас мэдээлэл багатай байсан. Тэгэхээр ингэж өгсөн эрх мэдлийг буруугаар ашиглаж, Сангийн яамыг ер нь Засгийн газрыг дараа нь үе үе ингэж шахаанд оруулдаг, энд ирээд Хууль зүйн байнгын хорооны дарга нь Засгийн газартай байнгын зөрчилцөлд орж шүүхээс юм харамлалаа гэж үзэж тааруулах нөхцөл байдлыг албаар ингээд үүсгээд байвал бодлогогүй ийм байдлаар ашиглаад байвал буцааж авна наад эрх мэдлийг чинь. Ийм зүйлийг хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Яах вэ, ер нь энэ нийгмийн ойлголт, хүмүүсийн энэ хүлээж авч байгаа байдал энэ Улсын Их Хурал нь өөрөө ч гэсэн энэ Засгийн газар нь ч гэсэн хууль тогтоогчид, гүйцэтгэх засаглал, шүүх засаглал энэ юмныхаа учир начрыг ялгаж, амьдрал дээр зөв ойлгох ёстой байхгүй юу. Эцсийн эцэст шударга ёсыг тогтоодог, хуультай нийгэмд амьдардаг, эцсийн шийдвэрийг гаргадаг байгууллага чинь шүүх л байхгүй юу. Тэр бол төлбөргүй юм байхгүй. Тэр хүмүүсийг үнэхээр ажилдаа санаа зоволтгүйгээр ажиллуулж чадах тийм боломж нөхцөлийг нь хуулийн зүйл заалтаараа бий болгочихсон. Үндсэн хуулиараа ч тийм байгаа. Гэтэл энэ юмаа маш муу тайлбарлаж байна шүү. Тэр ойлголтыг нь өгөхгүй байна шүү. Энэ дарга нар ч гэсэн шал өөр юм яриад байна шүү. Тийм байж болохгүй. Хэрэв ийм ойлголттой байгаа бол бид нар ардчилсан нийгэмд амьдарч чадахгүй. Ардчилсан нийгэмд амьдрах баталгааны баталгаа бол Монгол Улсын шүүх байхгүй юу. Одоо тэгээд шүүхэд хэн дуртай нөлөөлж болдог, тийм юм шиг ойлголтыг нийгэмд өгөх гээд байгаа байхгүй юу. Өгөөд байгаа байхгүй юу. Энэ зүйл заалт арай өөр болоод арай дээшилж байтал буцаад л нөгөө 1990 оныхоо социализмд амьдарч байгаа юм шиг тэр лүүгээ орох гээд байна. Шүүхийг загнадаг хүн хэн ч байх ёсгүй шүү дээ. Шүүгч нарыг. Тэр чинь шүүхэд хараат байдал нөлөөлөх гэж оролдож байна гэсэн үг байхгүй юу. Тэгээд нөгөө талаар бол гуя дагаж хүзүү гэх шиг юм болох гээд Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороонд ажиллаж байгаа тэр албан тушаалтнууд байгаа. Шүүгч нар сонголт хийгээд, сонгогдоод ороод ирж байгаа байхгүй юу. Тэр дотор бол. Тэд нар бол ямар цалин авахаа сонгож болно. Яг тэр шүүгчийнхээ цалингаас буухгүйгээр тэр цалингаа авна. Энэ хүмүүс бол шал өөр шүү дээ. Ажилладаг байдал нөхцөл нь өөр байх. Өөрөө тэр сонгон шалгаруулалт шүүгчээр бол орж байсан, эндээс сонгогдоод явж байгаа ийм хүмүүс бол яг тэр цалингаа уг нь бол өгмөөр байна. Гэхдээ тэгж чадахгүй нөхцөлд бол яг тийм адилхан авах ёстой гэсэн ойлголт байхгүй шүү. Тэр албан тушаалтныхаа цалинг авахаас биш, яг шүүгч нартай адилхан байна гэсэн юм байхгүй.

Нөгөө талаар бол тэр доктор шүүгч, олон жил ажилласан шүүгч арай илүү цалин аваад, арай өөрөөр шийддэг юм гэж байхгүй. Бүх хэргийг бол яг адилхан л шударга шүүхээр шүүлгэх эрх Монгол Улсын иргэн болгонд байгаа байхгүй юу. Тэрийг нь л хангаж ажиллах ёстой. Тэрнээс биш хонгилын шүүгч, тэр орцонд явж байдаг шүүгч, тэгээд хэн нэг нь даалгавар өгч байдаг шүүгч гэж тийм юм байхгүй байлгахын төлөө л бид нар явах ёстой. Тийм ойлголтыг нь өгч байх ёстой шүү. Тэгээд мэддэг юмаа л би асуугаад байгаа юм л даа.

Энэ юмыг та нар яг албаныхаа үгээр тайлбарла. Ажилдаа яаж ханддаг юм. Энэ бүх тайлбарыг чинь өгөөд нийгмийн бодол энэ бүх юмыг чинь сонсоод тэр ард түмэн чинь арай өөрөөр харах ёстой байхгүй юу. Ийм хариултаа та нар бэлдэж ирж бай. Энэ ойлголтоо өгч бай. Манай гишүүд ч гэсэн Хууль зүйн байнгын хороонд бид нар хариуцлагатай сууж байгаа байхгүй юу. Энэ шүүх засаглал ямар учиртай юм гэдгийг бид нар энд тайлбарлаад сууж байх ёстой. Тийм хэмжээний хүмүүс энэ Хууль зүйн байнгын хороонд байх ёстой шүү дарга аа. Тэрнээс биш тэгээд нам эвсэл тийм байх ёстой, ийм байх ёстой гээд байх биш. Энэ эрх чөлөөтэй ардчилсан нийгэмд амьдардаг, Үндсэн хуульд заасан, тэр шүүхийнхээ тухай хуульд заасан тэр юмыг бид нар хэрэгжүүлж байх ёстой гэдгийг би зориуд анхааруулаад хэлчихье.

Д.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Сая гишүүдийн хэлж байгаа юмнуудыг анхаараарай. Яагаад гэвэл бас хэлэх ёстой үгнүүдээ гишүүд хэлж байна. Тэгэхээр Сахилгын хороо ч, Шүүхийн ерөнхий зөвлөл ч гэсэн энэ Сайнзориг гишүүнд бол та нар үндэслэл юмнуудаа үнэхээр сайн гаргаж өгөөрэй. Ийм ийм учиртай шүү гээд. Тэгээд энэ асуудлаараа санал хураалт явуулъя.

“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 53,8 хувиар санал дэмжигдлээ.

Гэхдээ нөгөө татгалзсан дотор Баасанжаргал гишүүнийг түдгэлзсэнд тооцож бүртгэж аваарай. Баасанжаргал гишүүн энэ дээр бол маш юу хандаж байгаа шүү. Би энийг нээрээ нэг бус удаа цохож хэлж байгаа. Яагаад гэхээр Монголд энэ ашиг сонирхлын зөрчлийн хуулийг зөвөөр тайлбарлаж бид нар хэрэглэж сурахгүй бол ашиг сонирхлын зөрчил байна гэхээр нэг муу муухай юм байгаа юм шиг ингэж ойлгоод, сүүлдээ тэрийгээ хүн муу муухай гээд байхаар чинь ашиг сонирхлын зөрчилтэй байсан ч тэрийгээ хүн хэлж чадахаа больчихож байгаа байхгүй юу. Тэгтэл ашиг сонирхлын зөрчил гэдэг чинь эрүүл амьдралд байдаг юм. Тэрийгээ харин ил тод хэлээд аливаа санал хураалтад ийм байгаа гэж үзэж байгаа бол оролцохгүй байх нь харин ёс зүйтэй зөв зүйл байгаа байхгүй юу. Тэгээд энийг бол тал талдаа бид нар анхаарч байх ёстой гэж бас хэлмээр байна. Нээрээ бас тийм шүү. Үнэн энэ чинь түдгэлзэх эрхийг нь компьютероор байхгүй болгочоод байна гэсэн үг байхгүй юу.

“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулна.

16.52 цаг.

Дараагийн асуудалдаа орёе.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг та бүхэнд уншиж танилцуулъя.

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай.

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан саналаа холбогдох хуульд заасны дагуу ирүүлсэн бол холбогдох Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасны дагуу мөн Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдөр өргөн барьсан 01/1009 тоот, 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/2013 тоот хүсэлт уламжлах тухай, Шүүхийн сахилгын хорооноос Хууль зүйн байнгын хороонд 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдөр 01/40 тоот, 2024 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 01/88 тоот хүсэлт уламжлах тухай албан бичиг ирүүлснийг тус тус үндэслэн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг, мөн энэ тогтоолын 4 дүгээр хавсралтаар Шүүхийн сахилгын хорооны дарга, шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг, 5 дугаар хавсралтаар бүх шатын шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг тус тус тогтоосон.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Шүүх байгуулах тухай хуулийг шинэчлэн батлахдаа Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг Ерөнхий зөвлөл шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг өөрийн батлагдсан төсвийн хүрээнд тогтоож нэмэгдэл олгох журмыг батална гэж заасан. Үүний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг тогтоох, олгох журам батлах тухай 273 дугаар тогтоол, Шүүгчийн албан тушаалын цалин нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай 274 дүгээр тогтоолыг тус тус баталсан.

Иймд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.10, 95 дугаар зүйлийн 95.10 дахь хэсэгт нийцүүлэн Шүүхийн ерөнхий зөвлөл, дарга, шүүгч бус гишүүн, Сахилгын хорооны дарга, шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг тогтоосон Монгол Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоол, түүний 3, 4 дүгээр хавсралтад холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, 5 дугаар хавсралтыг хүчингүй болгох хэрэгцээ шаардлага бий болсон.

Иймд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, шүүгч бус гишүүн, Сахилгын хорооны дарга, шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг өмнөх практикийн нэгэн адилаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээтэй дүйцүүлэн шинэчлэн тогтоохоор, мөн бүх шатын шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоосон Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгохоор тусган тогтоолын төслийг боловсруулсан.

Хоёр.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал байж байгаа.

Үүнд бол энэ бүх шатын шүүхийн шүүгчийн цалин, нэмэгдлийн хэмжээг тогтоохдоо Шүүхийн ерөнхий зөвлөл 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд багтаан тооцож тогтоосон бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, шүүгч бус гишүүн, Сахилгын хорооны дарга, шүүгч бус нийт 10 гишүүний албан тушаалын цалингийн хэмжээ нэмэгдсэн зөрүүг тооцож, 2025 оны төсөвт мөн тусгасан байгаа болно.

Ингээд тогтоолын төслийг уншиж танилцууллаа. Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Номинчимэг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Тогтоолыг зарчмын хувьд дэмжинэ. Тэгэхдээ 1 зүйлийг би зүгээр техникийн хувьд бас хэлчихье гэж бодож байгаа. Тогтоол дээрээсээ энэ 5 дахь заалтыг нь ер нь аваад хаячихдаг юм уу даа. Ердийн журмаар яваад, Төрийн мэдээ сэтгүүлд хэвлэгдээд цаашаа үйлчлээд явна биз. Би ийм байр суурьтай байна. Өөрөөр хэлэх юм бол тогтоолын он сар тавиагүй хэсэг. Яг хэднээс дагаж мөрдөх вэ гээд тэр хэсгээ бүр аваад хаячихвал яадаг юм бэ гэж бодож байна. Тэгээд яг л ердийн журмаараа Төрийн мэдээ сэтгүүлд хэвлэгдээд, тэгээд цаашаа үйлчлээд явна биз.

Энэ дээр зүгээр нэг зүйлийг бас редакцын саналтайгаар, эсвэл бид нар санал хураалгах ёстой юу мэдэхгүй байна дарга аа. Энэ докторын зэргийн нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 20 хувь гээд байгаа юм. Нийтлэг байдлаараа энэ чинь төрийн албанд 10 байгаа шүү дээ. Тэгээд бид хэд нэг ийм онцгой байдлыг л нэг хүнд, хэсэг бүлэг хүмүүст ийм хэт давуу байдлыг зарчим тогтоох гээд ядаад байхаар ингээд сондгой орж ирээд байгаа юм. Энийгээ больчихье. Би бүр түрүүчийн удаа ч хэлсэн. Тэгээд юмнуудаа засчхаач ээ, хэрэггүй. Энэ төрийн албаны төрийн албан хаагчид баригддаг нийтлэг зарчмыг барьчхаач ээ л гэж гуйгаад байгаа юм.

Сая Ганбат даргатай би санал нэг байна. Ганбат гишүүн хэлж байна шүү дээ. Доктор шүүгч, доктор бус шүүгч 2-оор шүүлгүүлж ялгаагүй. Ялгаагүй л хууль тогтоомжийг нийтлэг байдлаар хэрэглэж, шударга ёсыг л тогтоох ёстой. Тэгээд ингээд эд нар нь хүртэл ийм нэг онцгой байдлаар нийт төрийн албан хаагчид 10 хувь авч байхад 20 хувь болгоод л нэг ийм юм руу л түлхээд байх юм. Ерөөсөө бүүр ойлгохгүй юм. Больчихож болох уу. Тэгээд Мөнгөнчимэг дарга бас ажлаа удаагүй байгаа байх гэж бодож байна. 2 долоо л болж байна уу. Тэгэхээр энэ өмнө нь боловсруулсан хүмүүс маань анхаар л даа. Би гуйж байна.

Тэгэхдээ ер нь зүгээр энэ хар даа. Цалингийн нэмэгдэл энэ тэр дээр ядаж жилдээ 1 удаа нэмэх шийдвэр гаргадаг байхгүй бол 2 удаа угсруулж гаргах, тэгээд Сангийн яам, Засгийн газрыг шахаанд оруулах. Докторын нэмэгдэл нь төрийн албан дээр 10 хувь байхад 20 хувь болж ирэх гээд ийм л нөхцөл байдлуудыг шүүгч нар өөрөө шударга ёсыг бас зөвхөн шүүгч нар энийг яриагүй байх. Би энэ дээр Шүүхийн ерөнхий зөвлөл маань шүүгчдээ битгий ингэж муухай харагдуулаач ээ л гэж хүсэж байна.

Тэгэхээр энэ дээр редакцын хувьд энэ 20-ийг 10 болгомоор байна. Тэгээд 5 дахь заалтыг хасаад, бусад зүйлүүдийг нь бол дэмжиж байна.

Д.Цогтбаатар: Энэ чинь асуулт биш. Та чинь санал яриад явчихлаа шүү дээ. 5 дугаар микрофон өгье.

Л.Энхбилэг: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Бид нар 2024 оны 11 сарын 28-ны 273 дугаар тогтоолоороо Шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг тогтоох, олгох журам баталсан юм. Журмынхаа 3, 4-тэй яг энэ нөгөө санхүүгийн сахилга баттай байхын тулд шүүгчийн цалинг ер нь бол 4-5 жил тутамд нэмэхээр оруулсан. Хугацаатай. Өөрөөр хэлбэл 3 жил тутам хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт гаргуулахаар. Тэр 3 жилийн үнэлгээг хийсний дараа ажлын алба дараагийн жилд нь Ерөнхий зөвлөлдөө танилцуулаад, Ерөнхий зөвлөл дараагийн жилийнхээ төсөвтөө тэр нэмэгдвэл шаардлагатай эсэхээ төсөвтөө тусгаад ингээд явах юм. Яг жил болгон ч юм уу, жилд 2 удаа ч юм уу, нэммээр санагдсан үедээ нэмэхээр тэгж бол бид нар санхүүгийн сахилга баттай байхын тулд журамд ийм юм оруулчихсан байгаа шүү гишүүн ээ. Ер нь бол 3 жил тутамдаа хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ. Дараагийн жил нь ажлын алба ерөнхий зөвлөлд танилцуулна. Тэрний дараагийн жил нь Ерөнхий зөвлөл төсөвтөө тусгах эсэхээ шийдээд ингээд өөрөөр хэлбэл 5 жилийн циклтэй шүүгчийн цалинг нэмэх эсэх асуудлыг яриад явах юм. Журмаар тэгээд журамлачихсан байгаа юм. Тэгэхээр бол энэ дээр бол жил болгон төсөвт ингээд хүндрэл учруулаад, өөрт олгосон эрх хэмжээгээ хэтрүүлж ашиглах гээд байгаа юм огт ерөөсөө байхгүй. Журамлачихсан байгаа юм.

Докторын 20 хувь дээр бол хуучин нөгөө хаврын чуулганаас өмнө орсон өөрчлөлтөөр бол Шүүхийн тухай хуулийг дагаад төрийн албан хаагчийн докторын зэрэг профессорын цолны нэмэгдэл олгох гэдэг дээр яг шүүх дээр бол доктор бол ялгамжгүйгээр 20 хувиар тогтоохоор Их Хурлын тогтоол байгаа юм.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн ээ, бид нарын саяын нөгөө хүчингүй болгодог тогтоол байна шүү дээ энэ дээр чинь 20-иороо угаасаа л байж байгаа юм байхгүй юу. Тэгэхээр энэ одоо бол бид нар яг энэ хэмжээндээ л явж байгаа. Харин энэ саналыг нь хэдүүлээ жич тэгвэл ярья. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Мэдээллийг авлаа. Тэгээд 1 зүйл байна. Журмаар бол би 3 жил тутам шүүгч нарын цалинг эргэж харна гэдэг дээр бол би буруу гэж бодож байна. Шүүгчдийн цалинг яг нийтлэг байдлаараа төрийн албан хаагчийн цалинг энэ жил 6 хувиар нэмэгдүүлж байвал яг энэ баримжаагаар нь ч гэсэн танай тэр төсвийг нь тавиад шийдэж байх ёстой. Дараа нь энэ 3 жилийн зөрүү чинь огцом нэмэх гээд тэгэхээр их томоор нэмэгдэж байгаа юм шиг нийгэмд уур амьсгал өгөөд байгаа байхгүй юу. Та нар өөрөө энэ шүүгчийн албан тушаал хийж байгаа хүмүүсийг улам эрсдэлд оруулаад байна. Энэ журмаараа. Тэгэхээр наад журам чинь болохгүй ээ. Хууль дээрээ журам тогтоогоод ерөнхийдөө бас тодорхой хэмжээнд богино хугацаанд нэмж байх. Тэгэхдээ энэ цаад талын хугацаа 3 жилийн дараа энэ тэр гэж харахгүйгээр Засгийн газрын барьж байгаа төсвийн, мөнгөний бодлоготойгоо танай бие дааж хэрэгжүүлэх эрх мэдлийнхээ хүрээнд бас Сангийн яамтайгаа зөвшилцөөд магадгүй жил тутам ч жоохон жоохноор нэмэгдүүлээд явах бололцоог нь бид нар харах ёстой байхгүй юу. Яг 3 жилийн дараа та хэд 15 хувиар хоцорчихно. Тэгээд нөгөө бусад албатайгаа адилхан харагдаад огцом нэмэх гэхээр энд хэдэн гишүүд .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Энэ зүгээр яах вэ, энэ нэмж байгаа цалингийн хэмжээ бол ер нь 14-19 хувьтай л нэмж байгаа юм байна л даа. Тэгэхээр яах вэ, төрийн албан хаагчдын цалинг бол бид нар төсөв дээр 6 хувиар нэмж байгаа. Тэгээд ерөнхийдөө болохоор ингээд жил болгон хэрвээ жишээлбэл, инфляц ч гэдэг юм уу юм өсөөд байхаар ингээд цалин нэмэх асуудал орж ирэх гээд байгаа байхгүй юу. Тэгээд би энэ бас нэлээн л том ажил болдог байх гэж бодоод байгаа юм. Ажил талаасаа бодохоор. Яагаад гэхээр хүмүүс ажил хийж байгаа бас цалин хөлсний асуудал байнга яригдана. Тэгэхээр уг нь бол зүгээр тодорхой хэмжээнд Төрийн албаны зөвлөлийн харьяаны тэр байгууллагуудтай уялдсан цалингийн индекстэй. Тэндээсээ явчихдаг байвал та хэд ингээд л жил болгон орж ирэх шаардлага байхгүй байсан юм биш үү гэдэг нэг ийм санал байгаа юм. Энийг зүгээр яах ёстой юм. Ямар хууль журамд өөрчлөгдөх юм. Энэ дээр бас бодох ёстой юм болов уу гэж бодож байгаа юм.

Тэгээд 2 дугаарт бас хэлэх гээд байгаа санаа гэхээр ерөнхийдөө бол 5 сая 760 болгож байгаа, 5 сая 580 болгож байгаа нь болохоор бол яг өнөөдөр энэ хүмүүс түрүүн Ганбат гишүүний хэлээд байгаа ажлаа хийх, шударга хангалттай хийх хэмжээний мөнгө төгрөг мөн байна уу, биш байна уу гэдэг дээр бол бас дүгнэлт гарах ёстой л байх л даа. Тэгэхгүй болохоор та хэд өөрсдөө ингээд Төрийн албаны зөвлөлөөс тусдаа санал оруулж ирээд ингээд яваад байхаар энэ нь болохоор бол төрийн албаны явж байгаа юунаас харьцуулахад ямар байгаа гэдгийг нь мэдэхгүй болохоор энэ саналаар чинь баталчхаж байгаа байхгүй юу.

Гэтэл магадгүй 7 сая байсан ч юм уу, 8 сая байсан юм уу. Мэдэхгүй шүү дээ. Тэгэхээр би бол уг нь энэ төрийн албаныхаа жишигтэй, тэгээд тэр бие даасан, хараат бус байх нөхцөлийг нь хангасан тийм цалингийн хэмжээний индексийг нь баталж өгөөд л тэгээд л тэр нь төсөвтэйгөө хамт явдаг байсан бол ийм асуудал ингээд л дахин дахин яригдаад байхгүй байсан юм болов уу даа л гэж бодож байгаа юм. Тэрийг л хэлэх гэсэн юм.

Д.Цогтбаатар: Асуулт биш. Зүгээр санал гээд ойлгочихъё. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Миний асуулт маш тодорхой. Зөв тээ, нөгөө хавсралт маань. Энэ нөгөө тоогоор илэрхийлээд байгааг нь л би жоохон гайхаад байна л даа. Тэгээд энэ чинь байнга дахиад өөрчлөгдөөд явах юм уу. Нөгөө зэрэг дэв эсвэл нөгөө давж заалдах шатны шүүхийн шүүгчтэй, Ерөнхий шүүгчтэй адилхан байх ёстой гэж байгаа бол тэрийгээ бичээд явж болдоггүй юм уу. Тэгээд байнга л нэг ийм шүүгчийн цалингийн хэмжээг тойрсон яриа болоод л, нийгмээрээ хэлэлцээд л. Энэ асуудлыг жоохон, энэ ч уг нь нэг их аймар бодлогын гээд байх юм байхгүй. Зүгээр ер нь жоохон юу талаасаа бодож, тэгээд энэ хэмжээг заавал ингэж тоогоор ингэж тавих ёстой байдаг юм уу гэдэг дээр л гайхаад асууя гэж бодсон юм.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс аль микрофон бэ. 3 хариулчих. Би бас нэмээд нэг тайлбар энэ дээр хийнэ.

Д.Ариунтуяа: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Ер нь бол Шүүхийн сахилгын хороо болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс яг энэ асуудалдаа

бол уг нь бол таныхаар санал оруулсан юм. Яагаад гэх юм бол Шүүхийн ерөнхий зөвлөл ингээд шүүгчийнхээ цалинг мэддэг болчихсон. Энэ өөрчлөх тоолонд Улсын Их Хурлын тогтоол бас өөрчлөгдөхгүйд бид нар ингээд араас нь яваад байгаа юм шиг ийм нөхцөл байдал үүсэх учраас энийг дүйцүүлэх байдлаар үгээр Улсын Дээд Шүүхийн Сахилгын хорооны дарга нь Улсын Дээд Шүүхийн шүүгчтэй, харин гишүүн нь давж заалдах шатын шүүхийн шүүгчтэй дүйцүүлэх байдлаар гаргах юм бол дахин дахин Их Хурлын тогтоол өөрчлөлт орох эрсдэл үүсэхгүй.

Нөгөө талаараа ингээд шүүхийн цалин хөдлөхөөр бид нар цалингаа нэмүүлээд яваад байхаар нь бас жоохон зохимжгүй харагдах гээд байна. Тэгээд Их Хурлын тогтоол байн байн орж ирэхээр байна гэсэн ийм саналаар оруулсан боловч ингээд сүүлдээ бас энд яригдаад, тэгэхээр бас хуулиар яг дүйцүүлсэн гэсэн юм байхгүй байна гэдэг агуулгаар өөрчилсөн юм байна гэж ойлгосон. Бид нарын санал бол ер нь дүйцүүлэе л гэдэг дээр саналаа өгсөн юм. Үгээр. Тоогоор биш үгээр явуулъя гэсэн тийм саналаа өгсөн байгаа.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүн байхгүй байна. Ганбат гишүүнд микрофон өгье.

Д.Ганбат: Нэг иймэрхүү л байгаа шүү дээ. Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн төлөөллүүд нь сууж байх шиг байна. Та нар чинь шүүгч, зөвлөлийн гишүүн, шүүгч бус гишүүн гэж байгаа. 5, 5 байдаг ч билүү. Тэгэхээр та нар бас нэг ийм юм ойлгох хэрэгтэй. Сая тэр журам гэдэг юмаа тайлбарлаад байх шиг байна Шүүхийн ерөнхий зөвлөлөөс. Тэрийгээ хуульдаа л нийцүүл л дээ. Энэ чинь тэр шүүгч өөрөө ямар нэгэн байдлаар эдийн засгийн боломжтой байх, хараат бусаар, хуульд нийцүүлж, итгэл үнэмшилтэйгээр энэ асуудлаа шийдэх ийм боломжийг нь хангана л гэхихсэн юм байгаа шүү дээ. Шүүгч нарын хувьд. Бид нар дарга нар, бид нар шүүгч нараас илүү цалин авах ёстой. Энэ тэр гэж бодож байгаа бол буруу. Ийм юм байх ёсгүй. Шүүгч нарын анхны цалинг нь боломжтой тавьж өгөөд, тэрийг инфляцад нийцүүлэх ёстой байхгүй юу. Юмны үнэтэй. Тэрнээс биш 4, 5 жилд 1 нэмж байя энэ тэр гэсэн тийм ойлголт байж таарахгүй. Жил болгон л инфляцад нийцүүлээд л өөрчлөгдөөд л орж байхаар. Бараг манай Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурлаар бид нар хэлэлцээд байх шаардлага байхгүй. Тэр байтугай энэ чинь бол шүүгчид нөлөөлж байгаа асуудал болчхоод байгаа байхгүй юу. Бид нар чинь цалинг нь тогтоож өгөөд. Яах вэ дарга нарынхыг чинь ярьж болох юм бид нар. Ийм зарчимтай шүү. Энийг л ойлгуулах гээд л, ойлголцох гээд л бид нар ингээд яриад байна шүү дээ. Нөгөө талаар бол шүүгч асуудлыг шийдэж байхдаа бол хуулийг бариад итгэл үнэмшлээрээ шийднэ. Тэрнээс биш тэр баян хүнд нь өөр шийдээд, дарга хүнд нь өөр шийдээд ингээд байх ёсгүй. Тэгэх гэж л энэ юмыг нь хангаад байгаа шүү дээ. Тэгж байж гаднын хөрөнгө оруулалт орж ирж байна. Тэгж байж хүмүүсийн итгэл үнэмшил бий болж байна. Нөгөө Үндсэн хууль чинь биелэгдэж байна. Хүний эрх чинь та нарын тэр шүүгч нарын юун дээр алх дээр зогсож байна. Ийм л учиртай шүү дээ. Тэрнээс биш дарга хэлээд ч юм уу, баян хүн хэлээд ч юм уу ингэж шүүхийн өмнө бүгдээрээ хуулийн өмнө эрх тэгш үйлчлүүлэх ёстой гэдгийг л нийгэмд сайн ойлгуулаад, тэрнийхээ дагуу хийдэг болоод ингэж явах ёстой юм. Энийгээ та нар маань ойлгохгүй энд ингээд ярьж байхад чинь нийгэм яаж ойлгох юм. Ингэж болохгүй шүү. Энэ талаар одоо та нар зөв зүйтэй, тэрнийхээ дагуу ярьдаг байх хэрэгтэй. Нийгэм ч гэсэн ойлгодог байх хэрэгтэй гэсэн ийм бодолтой байна.

Тэгээд шүүгч нар чинь хамаг юмаа л хасуулж байгаа шүү дээ. Шүүгч нар бол гудамжинд архи уугаад яваад байж болохгүй. Айлд очоод найрлаад байж болохгүй. Ийм хамаг эрхүүдээ хасуулдаг шүү дээ. Тийм байхаа. Ийм л юм байгаа. Тийм хүмүүсээр бид нар асуудлаа шийдүүлэх гээд тийм шаардлага тавиад, тэгээд бид нар яг тэр юу билээ, юу больё гээд байдаг билээ манай Ардын намынхан чинь. Тэгээд чаддаггүй чинь. Япон лугаа хөгжье гээд байдаг билүү. Шал эсрэгээрээ ярьчихаад эсрэгээрээ л яваад байгаа юм л даа. Тэнд чинь тийм байдаг юм шүү гэдгийг хэлье. Тэр тал руугаа явах ёстой шүү.

Д.Цогтбаатар: Зөв зөв. Ганбат гишүүний тэр манай намыг муулж байгаа хэсэгтэй нь би санал нэгдэхгүй байгаа юм. Түүнээс тэр саяын зарчмын тавьсан асуудлууд бол яг зөв асуудал тавьж байгаа шүү. Тийм тэр юун дээр нэг ийм асуудал байгаа шүү Баасанжаргал гишүүн ээ.

Нээрээ сая эндээс орж ирсэн санал нь бол дүйцүүлэх гэж тоо тавиагүй орж ирсэн юм. Тэгээд яах аргагүй Тамгын газартай ярьж байгаад энэ дээр бол нөгөө хэмжээ гэж заасныг энэ заавал тоо тавина гээд. Тэгээд хамгийн гол нь тогтчихсон бас яг амьдралын хуулийн хэрэгжилтийн практик чинь өөрөө үр дүнгүй зүйл биш байгаа байхгүй юу. Энэ чинь нөгөө тэр хэмжээ гэдгийг тоо гэж ойлгоод өдий болтол дандаа тоо тавиад ирчихсэн болохоор одоо энэ дээр нь шууд өөрчилчхөж болохгүй байгаад байгаа ийм нөхцөл үүсэж байгаа юм. Таны тавьж байгаа, сая Ганбат гишүүний ярьж байгаа яг зөв. Асуудал юундаа байна гэхээр яг ингэх байхгүй юу. Одоо инфляцтай та жишээлбэл нийцүүлнэ гэж байна шүү. 1990-ээд оны үед инфляц 320 хувь билүү дээ байсан үе бий байхгүй юу. Иймэрхүү нөхцөлд цалин бол ёстой хэд ч өөрчлөгдөж магадгүй. Өөрчлөгдөх болгонд шүүгчийн цалинг бид нар энд оруулж ирээд ярихаар гишүүд яг л энэ асуултуудаа, яг л энэ алергидсан байдлаа яагаад та нарын цалин нэмэгддэг юм бэ гээд л ингээд нөгөө шүүгчдийн чинь хараат бус биш, жинхэнэ нөлөөндөө авч эхэлж байгаа байхгүй юу. Тэгэхээр уг нь бол тэр дүйцэх гэдэг үгээрээ цаашдаа явах ёстой. Тийм учраас би энд юу хэлчихмээр байгаа юм. Энэ ажлын хэсгийнхэнд энийгээ давтуулахгүйн тулд яах ёстой вэ гэхээр хуульдаа зохих өөрчлөлт оруулах саналаа та нар боловсруулж оруулж ирээрэй. Тэгж хуульдаа өөрчлөлт оруулахгүй бол өнөөдрийн энэ явж байгаа практикийг чинь зөрччихлөө гээд эрх зүйн ямар үр дагавар гаргахыг нь би л лав дүгнэж болохгүй болчихоод байгаа байхгүй юу. Тийм учраас өнөөдөр энэ байдлаараа ямар ч байсан тэр тогтсон практикийнхаа хүрээнд орж ирж байгаа. Та нар энийгээ оруулж ирээрэй.

Ганбат гишүүн ээ. Энд бас нэг юу байгаа шүү. Энэ нөгөө шүүгч бус гишүүний цалинг нөгөө шүүгчидтэй дүйцүүлж олгох нь тэгэхгүй бол болохгүй байгаа юм. Эд нар чинь нөгөө хийж байгаа ажил нь яг нэг ажил байхгүй юу. Тэгээд 2 хүн яг нэг ажил хийчхээд нэг нь өөр цалин хийж байгаа нэг л ажлын төлөө, нөгөөдөх нь өөр цалинтай байгаад байж ёстой болохгүй. Энэ чинь нөгөө ялгаварлан гадуурхсан болчихоод байгаа байхгүй юу. Шүүгч бус гишүүдийнх нь тухай. Үгүй ээ үгүй, харин тэгэхлээр байна шүү дээ, одоо хэрэглэж байгаа. Тийм учраас би нөгөө хуулиа өөрчилж оруулж ир гэж хэлээд байгаа нь энэ байх. Тэгэхгүй бол байна шүү дээ жинхэнэ байдлаараа та нар өөрсдөө ч над дээр асуудлаа оруулж ирэхдээ ингэж яриад байгаа юм. Шүүгчид шүүгчийнхээ цалинг авч байгаа гээд. Үгүй та нар Шүүхийн ерөнхий зөвлөл гэдэг ажил хийгээд, эсвэл Сахилгын хороо дээр ажил хийж байгаа учраас тэрнийхээ цалинг авч байгаа болохоос биш, тэрийгээ авахдаа дүйцүүлж тооцож байгаа чинь шүүгчийнхээ цалинтай дүйцүүлж тооцоод байгаа болохоос биш шүүгчийн ажил хийгээгүй байж шүүгчийн цалин авч болохгүй

байхгүй юу. Тэр чинь угаасаа тэр байгууллагын тэр хэлээд заншчихсан нь ерөөсөө шүүгчийнхээ цалинг авна гээд. Тэгээд шүүгчийнхээ ажлыг хийгээгүй байж шүүгчийн ажлаа хийж байгаа юм шиг цалингаа авч яваад, одоо энэ чинь энэ яах аргагүй энэ асуудлыг үүсгэж байгаа юм. Тэгэхээр тэр хуульд чинь илүү тодотгол тайлбар юмнууд үнэхээр хэрэгтэй байна шүү. Яагаад гэвэл байна шүү дээ. Ингэхгүй бол та нар дахиад 3 сарын дараа юм уу, 4 сарын дараа орж ирнэ. Яг энэ асуудлуудтай тулна. Тэгэхээр тэр дээрээ та нар хуулиа боловсронгуй болгож, тэр санал, дүгнэлтээ оруулж ирээрэй л гэж хэлэх гэсэн юм.

Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу. Үг хэлэх гишүүн алга байна. Ингээд “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Түр зогсооё. Яг үнэн өөрийг чинь зөв байх. Хасаад ердийн тэр журмаар. Тэгэхдээ наадхыг чинь би тэгэхээр хасаад.

Тэгвэл саяын энэ Сайнзориг гишүүний хэлсэн саналыг би бол зөв гэж үзэж байна. Тийм учраас энэ дээрээ манайхан Байнгын хорооныхон энийгээ тусгаад оруулаарай. Ингээд санал хураалтыг түр хүлээлгэж байгаад, дараа нь нэгтгээд санал хураагаад явчихъя.

17.16 цаг.

3 дугаар асуудалдаа оръё.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй төсөлтэй холбогдон орж ирж байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Т.Энхболд Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, Б.Баярсайхан Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн албаны дарга, ахлах комиссар, Ц.Баасандэлгэр Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Ингээд тогтоолын төслийг гишүүддээ тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүн байхгүй байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү. Алга байна. Тэгвэл ажлын хэсэг түр хүлээж байгаарай. Ингээд 3 дугаар асуулт санал хураалт. Байж байгаарай. Түрүүний энэ 2 дугаар асуудал дээр Цогтбаатар гишүүн орчихсон байгаа юу.

Тэгвэл түрүүчийн 2 дугаар асуудал дээр би уншаад танилцуулчихсан байгаа. Тэгээд энэ дээр санал хураалт яваад дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 61 хувиар санал дэмжигдлээ.

Одоо 3 дахь асуудал. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал

хураалт явуулъя. 61,5 хувиар санал дэмжигдлээ. Ингээд эхний 3 тогтоолын асуудлуудыг хэлэлцэж дууслаа.

17.23 цаг.

4 дэх асуудалдаа оръё.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайланг хэлэлцье.

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайланг та бүгдэд тараасан байгаа. Нэр дэвшигч Чимэдийн Сайнбилэг, Соронзонболдын Халиунаа нарын танилцуулгыг та бүгд өөрсдөө авч танилцсан байгаа байх. Тараасан байгаа.

Ингээд нэр дэвшигчийн сонсголын тайлан болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Энэ чинь 2 гишүүн сонгох тухай асуудал. Тийм 2 хүнээ оруулаарай. Ороод сууцгаагаарай. Ингээд Да.Цогтбаатар гишүүн асуулт асууна гэсэн байна. Да. Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүнийг оруулъя.

Да.Цогтбаатар гишүүнд микрофон өгье.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Оройн мэнд. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшиж байгаа нэр дэвшигч нараас асуух асуулт байгаа юм.

Сүүлийн үед энэ хөрөнгийн бирж дээр босож байгаа хөрөнгө оруулалтуудаас банк бусууд маш их хэмжээгээр босгож байгаа. Тэгээд банк бусуудын үндсэн хийгээд байгаа бизнес бол хэрэглээний зах зээлийг дэмжсэн чиглэлд маш их асуудлууд, бизнесүүд нь хийгдээд байгаа л даа. 20 орчим хувиар, хамгийн ихдээ 20 орчим хувиар яригдах байх. Хөрөнгийн бирж дээр эх үүсвэрээ босгоод, цааш нь зах зээл рүүгээ гаргахдаа 40-60 хувиар гаргаж байгаа. Энэ чинь цэвэр зүгээр л дотооддоо мөнгө угаалт хийгээд байгаа гэсэн үг байхгүй юу. Тэгээд бид нар хэрэглээнийхээ энэ инфляцыг даахгүй байна, ханшийн хөөрөгдлөө даахгүй байна гэдэг яриад байгаа үндсэн шалтгаанууд д чинь 1 нь энд явж байгаа. Тэгэхээр та бүгд эндээс дэмжигдээд, чуулганаас дэмжигдээд тийшээ очих юм бол энэ банк бусуудын энэ хийгээд байгаа бизнесийнх нь хэрэглээг дэмжих биш, илүү энэ бизнесийг дэмжих чиглэлд хийхээр төлөвлөж байгаа ажлууд юу байгаа вэ. Энэ тал дээр та бүгдийн саналыг сонсьё гэсэн юм.

Д.Цогтбаатар: Энэ чинь хоёулангаас нь асууж байгаа юу. Тэгвэл 4 дүгээр микрофон өгье. Эхлээд Сайнбилэг.

Ч.Сайнбилэг: Баярлалаа. Гишүүний асуултад хариулахад ер нь бол таны хэлж байгаа ийм асуудал бол сүүлийн үед маш түгээмэл харагдаж байгаа. Гэхдээ хэрвээ миний хувьд Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилогдож очиж ажиллах тохиолдолд бол банк бусуудын үйл ажиллагааг зохицуулдаг дүрэм журмууд дээр байдаг зохицуулагдаагүй үлдчихсэн, таны саяын дурдаж байгаа эдгээр асуудлуудыг цэгцэлж болохоор зүйлүүд дээр бол Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох байгууллагуудаас нь мэдээлэл авч, цаашдын явуулж байгаа бодлого болон ирээдүйд явуулах бодлого энэ тэртэй

нь уялдуулж дүгнэж бол ер нь зохих дүрэм журамд нь бол өөрчлөлт оруулахаар ажиллах болно.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон. Халиунаа.

С.Халиунаа: Та бүхний өдрийн мэндийг эрье. 1 дүгээрт Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөл нь өөрөө яг хэдийг хууль дээр журам дээрээ санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааг хянадаг гэж заасан боловч зөвхөн идэвхтэй буюу гаргасан шийдвэрийнх нь хүрээнд, гаргасан шийдвэрийн гомдлынх нь хүрээнд асуудлыг авч хэлэлцдэг гэдгийг тодотгох хэрэгтэй байх. Гагцхүү журмын 2.1.4-д Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаатай холбогдуулаад саналаа өгөх гэсэн ажлынх нь хүрээнд хэрвээ бид нар ажиллах болох юм бол 1 дүгээрт ББСБ-ын хэрэглээний зээл бол нэлээн өндөр байгаад байгаа гэдэгтэй санал нэгтэй байна. Үүнтэй холбогдуулж манай Монгол Улсад Дампуурлын тухай хууль бол өнөөдөр яг бодит байдал дээр бол хувь хүн байтугай, аж ахуйн нэгжүүд дээр тэр болгон хэрэгждэггүй. Бид нар үүнийг сүүлийн хэдэн жил яаж шийдсэн гэх юм бол 210 мянган хуулийн этгээдүүдээс 50 мянган хуулийн этгээдийг өр төлбөргүй болон шүүхийн шийдвэрээр өр төлбөргүй, татварын болон шүүхийн шийдвэрээр өр төлбөргүй хуулийн этгээдүүдийг жагсаалт гаргаж байж, татан буулгасан байгаа. Тэгэхээр бид нар нэн тэргүүнд ийм Дампуурлын тухай хуулийг бол авч хэлэлцэх шаардлагатай. Зөвхөн аж ахуйн нэгжүүдийн болон хуулийн этгээдийн. Тэгэхээр банк бус санхүүгийн байгууллагууд дээр зөвхөн ингээд яригдаад явж байгаа өр төлбөрийн болон өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн хувь этгээдийн зээлийн хяналтыг сайжруулахаасаа гадна хэрвээ Хувь хүний дампуурлын тухай хуулийг батлуулчих юм бол банк бус санхүүгийн байгууллагууд маань өөрөө тухайн иргэдийн эрсдэлийг нь үнэлээд, зөвхөн эрсдэл даах чадвартай буюу санхүүгийн боломжтой иргэдэд ийм зээл олгох ийм байгаа юм. Юу гэхээр манай Монгол Улсын иргэдийн санхүүгийн боловсрол нь бас төдийлөн улс төрийн төдийгүй санхүүгийн боловсрол нь хангалтгүй байдаг учраас иргэд өөрийнхөө санхүүгийн даацаасаа хэт хэтрүүлсэн хэмжээгээр зээл авч байгаа. Энэ нь зөвхөн манай Монгол төдийгүй, Орос улсуудад хүртэл ингээд нэлээн томоохон эрсдэл үүсгэж байна. Санхүүгийн зах зээл дээр. Тэгэхээр хэрвээ бид нар нөгөө талдаа заавал банк бус санхүүгийн байгууллагуудын хэрэглээний зээлийг бууруулахаасаа гадна хэрвээ хувь хүний дампуурлын тухай хуулийг бас эхний ээлжид бол багахан үнийн дүнгээр баталсан тохиолдолд нөгөө талдаа ББСБ маань иргэддээ зээл олгохдоо сүүлийн үед бол энэ аппликэйшн дээр олгож байгаа зээлүүд бол нэлээн хавтгайрсан шинжтэй байгаа юм. Тухайн зээлийн мэдээллийн санд харгалзахгүйгээр ямар нэгэн урьдчилгаагүйгээр та шууд зээл авах боломжтой гэж байгаа юм. Тэгэхээр энэ маань өөрөө нэг талаасаа дампуурлын тухай хууль гаргах юм бол ингээд хумигдах боломжтой байгаа гэж өөрийнхөө хувьд харж байгаа.

2 дугаарт яах вэ, ерөнхийдөө бас гишүүд маань мөнгө угаах гэдэг дээр маш их хараад байдаг боловч зүгээр юун дээр тодруулаад хэлэхэд мөнгө угаах маань өөрөө дандаа хоёрдогч гэмт хэрэг байгаа. Тэгэхээр мөнгө угаагаад байна гэдэг дээр бол яг банк бус санхүүгийн санхүүгийн байгууллага маань харьцангуй Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс бол мөнгөний эх үүсвэр дээр бол харьцангуй хяналт тавьж байгаа байх. Тэгэхээр мөнгө угаах банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа мөнгө угаах гэхээрээ бас нэг талаас бас өрөөсгөл ойлголттой болж байгаа. Тэгэхээр мөнгө угаах маань өөрөө хоёрдогч гэмт хэрэг учраас эхний ээлжид эхний гэмт хэрэг нь юу байна вэ гэдэг дээрээ илүү анхаарал

хандуулах юм бол яг банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа бол хүүгийн хүүлэгч л гэж явах болов уу. Энэ дээр нэг тодруулга хийчихлээ.

Тэгэхээр ер нь бол Дампуурлын тухай хууль дээр л илүү анхаарал хандуулна гэж бодож байна. Хувь хүний болон хуулийн этгээдийн дампуурлын тухай хуулийн төсөл дээр Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаа дээр.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Энэ санхүүгийн чиглэлд хийх ёстой ажлууд бол их байгаа. Хэдийгээр нөгөө чөлөөт зах зээлд орсон нэртэй 30-аад жил явж байгаа боловч тэр шаардлагыг хангахуйц хэмжээнд бол ажиллаагүй байгаа шүү дээ. Санхүүгийн зохицуулах хороо маань нөгөө тэр үнэт цаасны хороо, энэ бирж дээр хийж байгаа арилжаанууд энэ бүх юманд хяналт тавих, тэр луйвар яаж явж байна, өнөөдөр бол банк санхүүгийн зах зээлийн ломбардын хүү гэхэд бол тийм хүүтэй бизнес хийх энэ тэр бол маш хүнд болчихсон л доо. Тэгээд та нар чинь ингээд Хяналтын зөвлөлийн 2 гишүүн ороод ирсэн юм байна. Та нар чинь ингээд цалин авдаг юм уу, авдаггүй юм уу. Тэгээд энд бол цалин авдаггүй л гээд байна. Тэгээд цалин авдаггүй юм бол та нарын ажиллах хөшүүрэг маань юу юм бэ. Та нарын энд ажиллах сонирхлыг юу татдаг юм бэ. Одоо би ойлгохгүй байгаа юм л даа. Би өөрөө тийм социалист коммунист хүн биш болохоор. Яах вэ ард түмнээс сонгогдсон хүн бол өөр. Ард түмнийхээ итгэлийг хүлээгээд ажиллаж байгаа над шиг хүн өөр. Хууль тогтоогоод. Ингээд үнэгүй ажиллаад өгье, цалингүй ажиллаад өгье гэсэн хүмүүс бол бүр л их сонин байгаа байхгүй юу. Та бүхнийг юу ингээд тийм итгэл үнэмшил төрүүлээд ингээд байдаг юм бэ. Та нар сургууль соёлд сурахдаа ч гэсэн бодвол төлбөрөө төлж л сурсан байлгүй. Төлөөгүй бол улс орон даасан бол тэрний хариуд ямар нэгэн юм өгсөн л байлгүй. Эсвэл тийм их өртэй болсон юм уу улс орондоо. Яг ямар учиртай юм бэ. Тэрийг нэг сонирхоодохье. Тэгээд гол зорилго.

Тэгээд нөгөө талаараа бас нэг юм байна. Юу байна вэ гэхээр та бүхэн Хяналтын зөвлөлийн гишүүн болчихоод та нарын ажиллах нөхцөл боломжийг яаж хангах юм. Тоног төхөөрөмж энээ тэрээ юм өгдөг юм уу. Бас өрөө тасалгаа өгдөг юм уу. Ямар байдлаар ажилладаг юм. Бодвол Улсын Их Хурлаар орж ирээд л ингээд хэлэлцэгдээд явж байгаа болохоор хариуцлагатай л ажил байж таарна л даа. Угаасаа ч хариуцлагатай ажил гэж ойлгоод байна. Тэгээд тэр шаардаад байгаа тэр хэмжээнд хийчих боломж бололцоотой юу. Нэг ийм л асуулт байна.

Д.Цогтбаатар: Хоёулангаас нь асууж байна уу. Тэгвэл 4 дүгээр микрофон өгье.

Ч.Сайнбилэг: Миний хувьд бол ажлын гараагаа банкны салбараас эхэлсэн. 25 жил ажиллаж байгаа. Сүүлийн 4 жил бол би хувийн бизнес эрхэлж байгаа. Гэхдээ таны асуултад хариулахад нэг зүйл байгаа юм. 2012 онд Улсын Их Хурлаар хадгаламжийн даатгалын тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэхтэй холбогдуулсан хууль батлагдсан. Үүнтэй холбогдуулаад Хадгаламжийн даатгалын корпорац байгуулагдаж байсан. Та тэр үед Эдийн засгийн байнгын хорооны дарга байсан. Хадгаламжийн даатгалын корпорацын нээлт дээр хэлж байсан таны нэг үг байдаг юм. Тэр юу вэ гэхээр энэ хадгаламжийн даатгалын тогтолцоо бол олон улсад хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан ийм тогтолцоо байдаг. Монгол Улсад энэ тогтолцоо ингээд нэвтрэх хуулийн боломж бололцоо олдож

байна. Та бүхэн энэ ажлаа сайн хийж хэрэгжүүлээрэй гэдэг ийм үүрэг даалгавар тухайн үед өгч байсан. Тэгэхээр таны яг үнэхээр тэр ажлыг бид нар 3 жилийн дотор хамт олноороо хийж хэрэгжүүлж чадсан. Энэ юу вэ гэхээр эхний удаадаа бол хадгаламжийг цуглуулдаг банкнууд маань өөрсдөө энэ хадгаламжийн тогтолцоог бол маш сайн дэмжсэн. Дээрээс нь иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, иргэдэд энэ хадгаламжийн даатгалын тогтолцоо гэдэг зүйл Монгол Улсад нэвтэрч орж ирлээ гэдэг энэ ойлголтыг маш сайн өгч, үүнээс болж санхүүгийн зах зээл дээрх энэ банкны тогтолцоо бол тогтвортой, найдвартай, савлагаагүй ажиллах ийм боломж бололцоо бол бүрдсэн гэж хардаг.

Миний хувьд энэ хяналтын зөвлөлд орж, Санхүүгийн зохицуулах хорооны ажилд оролцох ийм боломж бололцоог юу гэж харж байгаа вэ гэхээр энэ яг тухайлж хэлэх юм бол хадгаламжийн даатгалын тогтолцоо орж ирсэнтэй холбоотой бусад улс орнуудад байдаг энэ манай хөрөнгийн зах зээл хөгжихгүй байгаа, сул байгаад байгаа, хүмүүсийн оролцоо, айдас их байгаад байдагтай холбогдуулан энэ банкны хадгаламжийн даатгалын тогтолцоотой адилхан хөрөнгийн бирж дээр оролцож байгаа иргэдийн эрсдэлийг хамгаалсан энэ даатгалын тогтолцоог бас Монголд бий болгох талаар ажиллах болно гэж бодож байгаа.

2 дахь асуултын хувьд бол Хяналтын зөвлөл өөрөө орон тооны бус зөвлөл. Гэхдээ Санхүүгийн зохицуулах хороо дээр бол Хяналтын зөвлөлдөө зориулсан ажлын байр болон нөгөө хурлаас хурлын хооронд ажил явагддаг учраас ажлын албыг бол тусад нь гаргаж байгуулж өгөх байх гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Төсөв мөнгөний хувьд ч гэсэн Санхүүгийн зохицуулах хорооны төсөвт хамаарч ингэж явдаг юм байна лээ.

Д.Цогтбаатар: 3 хариулах уу.

С.Халиунаа: Хариулъя. 1 дүгээрт та маш зөв асуулт тавьсан байна. Баярлалаа. Багахан хэмжээний урамшуулал авдаг юм байна лээ. Яг нэр төдий гэж хэлж болохоор. Тэгээд хэрвээ жишээлбэл би 25 юм уу 26-тай байсан бол би хувийн салбарт илүү ажиллах байсан байх. Яг өнөөдрийн түвшинд гэх юм бол нийт 15 жил ажиллачихсан. Миний насны 40 гарч байгаа залуучуудын гол давуу тал нь бол 1 дүгээрт ипотекийн зээлүүдээ бүгдийг нь төлөөд авчихсан байна. 2 дугаарт гэх юм бол бас харьцангуй салбартаа 15-18 жил ажиллачихсан учраас туршлага хуримтлуулчихсан байна. Тэгээд би бол ерөнхийдөө сүүлийн 15-18 жил хувийн салбарт ажиллаж байсан учраас 1 талыг л хараад байна л даа. 2 дугаарт төрийн байгууллагууд дээр ажиллаад, хяналт тавиад ажиллаад үзэхэд одоо бол яг цаг нь болчихсон байна гэж орж ирж байгаа. Тэгэхээр энэ албан тушаалыг бол санхүүгийн гэхээсээ илүү өөрийнхөө хувь хүнийхээ алсын харааг харж байгаа.

Тэгээд дээрээс нь манай Монголын санхүүгийн зах зээл бол ихэнхдээ 91 хувь нь бол ерөнхийдөө зээлийн санхүүжилтээр төвлөрсөн байдаг. Би өөрөө бол компанийн эрх зүйгээр мэргэшсэн буюу Экюти финанс гэж ярьдаг хувьцааны зээлийн санхүүжилтээр өөрөө ажиллаж байсан учраас энэ дээр бас яг бодлогын түвшинд ажиллах боломжтой. Бодлогын түвшинд бол өөрөө өөрийгөө хувь нэмрээ оруулах боломжтой гэж харж байгаа учраас энэ дээр нэр дэвшсэн байгаа.

Урт хугацаандаа бол ямар ч тохиолдол бол хараат бус байдлыг бол мэдээж нөгөө санхүүгийн хараат бус байдлыг ярих, сөхөх хэрэгтэй. Тэгэхээр ямар ч байсан хэрвээ та сая хэлсэн. Санхүүгийн зохицуулах хорооноос өөрөө хараат байдаг. Тэгэхээр хэрвээ бид нарт жишээлбэл нөгөө материалтайгаа танилцах хамгийн наад зах нь ажлын байр байхгүй. Тэгээд дээрээс нь хамгийн наад захын принтер цааснаас авхуулаад бичиг хэргийн зардал авахгүй бол бид нар хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх боломжгүй. Тэгэхээр урт хугацаандаа бол ямар ч байсан хяналтын зохицуулалт буюу энэ бүх л төрийн агентлагуудыг супервайзер боардыг үйл ажиллагааг нь бүтэн хэмжээнд нь үргэлжлүүлье гэх юм бол төсвийн асуудлыг ярих хэрэгтэй.

Тийм учраас энэ дээр урт хугацаандаа анхаарна байх гэж бодож байна. Миний хувьд бол ямар ч байсан яг санхүүгийн гэхээсээ илүү урт хугацаандаа бодлогын хэмжээнд хувь нэмрээ оруулж ажиллая гэж ажиллаж байгаа учраас санхүүгийн эрсдэл бол даагаад, санхүүгийн тал дээр бол илүү бага харж байгаа гэж хэлж болно.

Д.Цогтбаатар: Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Сайнзориг гишүүн. Тэгэхдээ гишүүд ээ, нөгөө асуулт асуух боломж олгож байгаа дээр та нар тэр юугаа авчхаарай. Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Асуулт асууна.

П.Сайнзориг: Баярлалаа. Би тэгээд яах вэ, 2 нэр дэвшигчтэй сонголт дээрээс уг нь асуучихсан юм. Тэгээд асуулт асуухгүй гэж бодсон боловч бас яг үнэндээ хэлэхэд уг нь дэмжихмээр байгаа юм. Тэгэхдээ бас их эргэлзээтэй зүйлүүд байна. Би энэ анкетыг харуулж байгаад ярья. Та ингээд ерөнхийдөө ажилласан намтар дээрээ сүүлийн 4 жил бичиж чадахгүй байгаа. ах вэ, хувиараа бизнес хийж байгаа гээд байгаа. Би Сайнбилэгийн тухай ярьж байна. Чимэдийн Сайнбилэг.

2 дугаарт таны бүрдүүлж өгч байгаа буюу ажил эрхэлсэн гээд өөрийнхөө гараар бичсэн энэ анкет дээр 3 байгууллага байгаад байгаа боловч таны нийгмийн даатгалын шимтгэл төлсөн энэ мэдээлэл дээр Би Би Эс Вэлт ББСБ гэж гарч ирж байгаа. Та яагаад бичиж чадахгүй. Яагаад Улсын Их Хурлын нээлттэй сонсголоор энэ бүх зүйлүүдээ нээлттэй наад захын намтар дээрээ бичиж чадахгүй байгаад байгаа юм бэ.

2 дугаарт би өчигдөр асуулт асуусан. 1 ч асуултад нь хариулаагүй. Тэгээд одоо яах вэ, өөр дээрээ дүгнэлт өгч байгаа байлгүй дээ. Би эсвэл зүгээр хүчээр янз бүрийн хүн оруулчихсан юм болов уу гэж бас өмнөөс нь бодох юм. Тэгээд ийм нэг эргэлзээтэй зүйл байх юм. Тэгээд бас бодолцоорой. Тэгээд ийм сонин зүйл дээр ингээд бид хэд сүүлд нь дэмжээд явуулчихдаг. Улсын Их Хурал, Байнгын хороо нь өөрөө ийм эвгүй байдалд орох нөхцөл байдал байх юм биш биз дээ. Хариулж чадахгүй байгаа юм. Танаас би асуусан шүү дээ. Бас л асуусан өчигдөр. Та хариулаагүй. Яагаад энэ 4 жил дээр хэлчхэж болдоггүй юм бэ гэхээр болж өгөхгүй л байгаад байгаа юм. Тэгээд би энийг яах вэ Байнгын хорооны протоколд үлдэг гэж бодож байна.

Яах вэ зүгээр хамгийн сүүлд нь бас нэр дэвшигчдийн хариултуудаас бас би энэ дампуурлын эрх зүйн энэ тэр ярьдаг хүн орж ирж байгаад бас талархаж байна. Одоо бас энэ чиглэлийн хууль тогтоомжийг бас сайжруулъя гээд л явж байгаа. Бас мэргэшсэн хуульчид тун багатай. Бизнесийн орчныг эрүүлжүүлье гэвэл энэ

байгаад байгаа, Монгол Улсад үүсчихсэн байгаа энэ өрийн сүлжээг цэгцэлье. Энэ бизнесийн эрсдэлийг яг зарчмаар нь хуваарилдаг болъё. Татвар төлөгчдийг хамгаалъя. Дараа нь тэр ажлын байрыг, бизнесийг авч үлдье гэвэл энэ дампуурлын хууль тогтоомжийг зөв болгож байж бас хийх юм байгаа юм. Тэгээд энэ дээр бас өөрийн бодол, байр суурьтай, бас итгэл үнэмшилтэй, өнцөгтэй ийм хүмүүс энэ секторт дэвшиж байгаад нь бас талархаж байгаа юм. Зүгээр тэгээд энэ дээрээ би Халиунаагаас асуух юм алга. Би уг нь үг хэлье гэж бодож байсан юм. Тэгээд би бас таныг үг хэлээд дараа нь хариулт хийх боломжгүйгээр ингэж үлдээмээргүй байна. Гишүүд таныг дэмжсэн, дэмжээгүй гэж санал өгөх учраас та бас энийгээ зөв өнцгөөс нь тайлбарлах бололцоог нь олгох үүднээс би хурлын даргаас гуйгаад бас нэг тайлбарлах өнцөг шалтгаан байвал бас хэлчхээч ээ л гэж хүсэж байгаа юм.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофонд тайлбар хэлье.

Ч.Сайнбилэг: Баярлалаа. Боломж олгосонд. Анкетыг би гараараа бөглөсөн байгаа. Нөгөө анкет дээрх шаблонх нь зай нь тухайн үедээ нөхөж бичих ийм боломжгүй харагдсан юм. Гэхдээ 2000-аас би өнөөдрийг хүртэл өөрийн үүсгэн байгуулсан, одоо гүйцэтгэх захирлыг нь хийж байгаа Райф дистрибьютор гээд компанид ажиллаж байгаа. Одоо манай компани ажиллаад 4 дэх жил рүүгээ орж байна. Бидний хувьд бол ажил тогтож байна. Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр, борлуулалтын чиглэлээр ажилладаг ийм компани байгаа юм. Харамсалтай нь миний хувьд энийг бичих орон зай гараагүй юм.

2-т нь Би Би Эс Велт гэдэг компанийг би Шуудан банкнаас 2009 онд гарахдаа бас үүсгэн байгуулж ажиллаж байгаад 2011 онд худалдан авах, худалдах гэрээгээр өөр өмчлөгчид шилжүүлсэн байгаа. Одоо Би Би Эс Велт бол миний хувьд ямар нэгэн хамааралгүй ийм компани байгаа.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Заяабал гишүүнээр тасаллаа. Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье.

Ж.Алдаржавхлан: Санхүүгийн зохицуулах хороо бол нэг их тийм сонин хаалттай шахуу л байгууллага байгаа. Тэгээд би та хэдийг очиж ажиллах юм бол бас аль болох нээлттэй болгох талаас нь ажиллаасай гэж хүсэж байгаа юм. Төрөл бүрийн тусгай зөвшөөрлүүд олгодог. Тэгээд тусгай зөвшөөрөл болгоны ард дандаа тийм хүндэрсэн асуудлууд сонсогддог. Хэрвээ иргэдээс та бүгдэд танай хяналтын зөвлөлд ийм гомдол ирэх юм бол та бүгд бас эцсийн тултал нь ажиллаасай гэж нэгд хүсэж байна.

2-т нь ББСБ-ын дүрмийн санг нь байнга нэмдэг гэж байгаа юм. Гэхдээ нөгөө ББСБ чинь бичил зээл олгох ёстой байгууллага шүү дээ. Гэтэл бичил зээлийнхээ хэмжээг нэмдэг. Дүрмийн санг нь нэмдэг жил болгон. Тэгээд хэсэг бүлэг хүнд тохируулж ажиллаад байна гэсэн гомдлууд иргэдээс их ирж байгаа юм. Энэ Санхүүгийн зохицуулах хорооны дарга нар чинь ер нь бол тэгээд л дандаа л нэг ийм даргыг дагаж явсан улс төрийн л нөхдүүд байдаг шүү дээ. Байсан шүү дээ. Би энэ өмнөх даргад нь бас маш их шүүмжлэлтэй хандаж байгаа. Тэгээд тиймэрхүү хүмүүст зориулагдсан ч гэмээр юм уу. Банк бус санхүүгийн бол байгууллагын дүрмийн сан, тэр зээлийн стандарт энэ тэр нь их өөр байдаг юм байна лээ гэсэн

гомдлууд бас байна. Тэгэхээр та хэд очиж ажиллах юм бол бас энэ дээр хяналт шалгалтыг сайн хийж ажиллаарай гэж хүсэж байна.

Тэгээд бас чин сэтгэлээсээ бүр сэтгэл зүрхээ гаргаж ажиллах нь зөв байх гэж бодож байна. Нэгэнт төрийн алба Их Хурлаар орж ирээд томилогдоно гэдэг чинь бүх албан тушаалтнууд тэгдэггүй шүү дээ. Ер нь цөөхөн албан тушаалтнууд тэгдэг. Тэгээд сайн дураараа ч юм уу эсвэл хүн үнэхээр хүчээр чи энд орчих гээд байгаа бол больчихсон нь дээр. Тийм учраас өөрсдөө бүх хүчээ дайчлаад, иргэдээс ирж байгаа тэр гомдол, хүсэлтийг тултал нь сайхан шалгаж өгөөд энэ Санхүүгийн зохицуулах хороо аль болох нээлттэй болгох чиглэлээр нь ажиллаасай гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Эхний зүйл би өчигдөр бас орж ирэхэд нь сонсголоор орж ирэхэд нь хэлсэн. Маргааш бас бусад орж байгаа Санхүүгийн зохицуулах хорооны гишүүдэд нэр дэвшиж байгаа, удирдах албан тушаалд нэр дэвшиж байгаа хүмүүсээс ч гэсэн би бас яг энэ талаар тодруулна гэж бодож байгаа. Яг энэ орон нутаг руу хэрхэн хүрч ажиллах вэ гэдэг асуудал маш чухал байгаа. Орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсролын асуудалд анхаарах ёстой байгаа.

2 дугаарт Ганбат гишүүний асуулттай холбоотой нэг зүйлийг бас хэлэх нь зүйтэй байх. Их Хурлын гишүүдийг ч гэсэндээ яг ингэж асуумаар байдаг байхгүй юу. Сонгуульд 800 сая төгрөг зарцуулчхаад сарын 5, 6 сая төгрөгийн цалин авах гэж яах гэж ирдэг юм бэ л гэж асуумаар байдаг байхгүй юу. Яг адилхан. Өөр юм байдаг юм уу гээд. Гэтэл ийм асуултад та бүхэн бүгдээрээ л олон нийтийнхээ төлөө сайн сайхан үйл хийх гээд гээд л ингээд л хариулдаг. Гэхдээ үүнд бол би үл итгэх гэхээсээ илүүтэй нийгмийн сайн сайхны төлөө өөрийнхөө тодорхой нас, туршлага, тодорхой зүйлээ бас ийм зарцуулъя гэсэн ийм чин хүсэл эрмэлзэл олон залуучуудад байдаг юм шүү. Тэрэнд бас ийм итгэж найдаж, итгэл найдвартай байгаарай. Бүгдээрээ л бүх юмыг ингээд зоосны нүдээр ерөөсөө хардаг ийм зүйл бас биш ээ. Тэгээд нөгөө таны муу хэлээд байдаг коммунист гэдэг утгаараа биш, илүү социал демократ гэдэг утгаараа нийтийн сайн сайхны төлөө ийм зүрх сэтгэлтэй олон залуучууд байдаг. Тэгээд ийм залуучууд бас энэ төрийн албанд орж ирж өөрчлөлт шинэчлэлийг хийгээсэй гэж хүсэж байна. Ялангуяа энэ удаагийн Хяналтын зөвлөл бол маш чухал үүрэгтэй байх ёстой. Олон жил энэ Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөл огт ажиллаагүй. Тэгээд дээрээс нь зөвхөн гомдол ирэхээр л ажилладаг ийм байгууллага. Яалт ч үгүй л хууль нь тийм байгаа. Гэхдээ энэ хуульд өөрчлөлт оруулж болно шүү дээ. Тэгэхээр одоогийн энэ парламент бол шал өөр түвшинд бас ажиллая, шинэчлэлийг хийе, өөрчлөлтийг хийе гэж байгаа ийм парламентын гишүүд байгаа. Тэгэхээр яг энэ Санхүүгийн зохицуулах хороог амилуулахад холбогдох хууль тогтоомжийнх нь өөрчлөлтийг оруулах тал дээр та бүхэн ажиллаарай.

Тэгээд ялангуяа Санхүүгийн зохицуулах хороо энэ зах зээлийн нэг онцлог зүйл нь маш цөөн тооны хүрээнд ажилладаг, мэргэжлийн ийм хүмүүс ажилладаг ийм талбар. Энд ерөөсөө олон нийтийн хяналт байгаад л, иргэний нийгмийн байгууллага тэнд орж ирээд л, хянаад л, тэгэх боломжгүй бараг чадахгүй. Боловсрол мэдлэг гээд олон зүйл дутагдана тэнд. Тэгэхээр энэ маань улам ийм нөгөө хаалттай хуйвалдааны шинжтэй болохуйц ийм аюултай зах зээл байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ялангуяа Хяналтын хороо бүүр онцгой үүрэгтэй.

Тийм учраас гишүүд та бүхнийг нэр дэвшиж байгаа та бүхнийг хэрвээ сонгогдох юм бол онцгойлон ашиг сонирхлын зөрчлийн асуудал дээр онцгой анхаараарай. Дээрээс нь Санхүүгийн зохицуулах хорооны гишүүдийн ашиг сонирхлын зөрчил дээр бас анхаараарай. Санхүүгийн зохицуулах хорооны гаргасан шийдвэрт гомдол гаргахыг хүлээхгүйгээр ажиллах, дээрээс нь эс үйлдэхүй дээр нь ажиллах хэрэгтэй байгаад байгаа юм. Яг хяналт тавих ёстой юмандаа хяналт тавьдаггүй шүү дээ. Бид нарт хуулиар олгоогүй ээ ч гэдэг юм уу ингээд л баахан амьтан дампуурахыг хүлээгээд л сууж байдаг шүү дээ. Тэгэхээр яг ийм давлагаа дараагийн давлагаа явж магадгүй гэж би зүгээр хувьдаа одоогийн энэ зах зээл юмнуудыг харахлаар бол тийм давлагаа бол харагдаад л байна. Энэ аппликэйшний зээл 1 өдөр асуудал үүсгэнэ. Энэ цахим мөрийтэй тоглоом 1 өдөр асуудал үүсгэнэ. Тэгэхээр энэ мэт хяналтыг Санхүүгийн зохицуулах хороо хийхэд та бүхэн шахаж ажиллах ёстой.

Тэгээд та бүхний үгийг авахгүй, хяналт хэрэгжүүлэхэд хэрвээ хүндрэлтэй, төвөгтэй байвал ил тод зарлаарай. Олон нийтийн дэмжлэгийг аваарай. Бусад олон нийтийн үйл ажиллагаатай хамтарч ажиллаарай гэдэг ийм зүйлийг хүсэх гэсэн юм. Тэгээд төрийн үйл хэрэгт өөрийнхөө цаг завьг зарцуулах гэж байгаа та бүхэнд бас талархлаа. Баярлалаа гэж хэлье.

Д.Цогтбаатар: Да.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Миний асуулт асуусан зорилго ер нь Монголдоо хэрэгтэй гэдэг талаас нь ажиллая гэж зориглож орж ирж байгаад нь бол үнэхээр талархаж байгаа. Гэхдээ хариулт дотор нь болохоор зүгээр байгаа дүрэм журмынх нь хүрээнд ажиллая гэсэн нэг тийм хурц тод хүсэл зориг бол харагдсангүй гэж анзаарлаа. Гэхдээ Ганбат гишүүний асуугаад байгаа асуултад яах вэ, ажиллах орчин нөхцөлийг хангаад өгчих байх гээд бас нэг хүсэл зорилго бол илэрхийлэгдээд байна. Тэгээд сая Алдаржавхлан гишүүн ч хэллээ, Баасанжаргал гишүүн ч хэллээ. Бид нар байгаа дүрэм журмынх нь хүрээнд ажиллая гээд өмнөх байсан жишгээр нь ажиллаж байгаад явъя гэж байгаа бараг очоод ч хэрэггүй байхгүй юу. Тэгээд аль болох байгаа юмыг өөрчлөөд, сайжруулаад, улс эх оронд чинь ядахдаа банк бусуудтай холбоотой аппликэйшнийх нь зээлүүдийг яавал илүү байх, яах вэ тухайн үеийн санхүүгийн хэрэгцээг түр зуур хангадаг хүү багатайхан шиг бүтээгдэхүүн байгаа бол окэй хэнд ч хэрэгтэй. Гэхдээ энэ банк бусуудын олгоод байгаа зээл илүү улс орны хөгжлийг урагшлуулах бизнесийн зээл байгаасай гэдэг тал руу, эсвэл нэг ийм богино хугацаатай, өндөр хүүтэй яг банк бусыг ажиллуулаад байгаа хүмүүстээ илүү ашигтай байх биш, ард иргэдэд нэг илүү хүртээмж нь хүрсэн байх чиглэлд жоохон зорилготой, зоригтой, хугацаатай очоосой гэж хүсээд байгаа учраас л би тэр өмнөх асуултаа асуусан юм.

Тэгээд Алдаржавхлан гишүүн бас сая хэллээ. Өмнөх удирдлагуудынх нь үйл ажиллагаа бол яах вэ, сэтгэлд нь хүрээгүй юм байна. Миний сэтгэл бас яг энэ Алдаржавхлан гишүүнийхтэй бол ижилхэн байгаа. Аль болох нэг юм өөрчилчих. Тэгээд та нар өөрсдийгөө сая тодорхойллоо шүү дээ. Бид нар залуу хүмүүс байна даа. Очоодохье гээд. Очоод илүү олон улсын түвшинд сайжруулаад олон улсад манай Санхүүгийн зохицуулах хороог гаргаж ирээд үнэлэх юм бол аягүй л бол сүүл мушгиад явж байгаа юм. Энийг өшөө урагшлуулах чиглэлд ажиллаасай гэж хүсээд байгаа учраас л би өмнөх асуултаа асуусан.

Тэгэхдээ асуултад нэг жоохон сэтгэлд хүрсэнгүй хариулчихсан учраас би эсрэг кноп дарчих гээд л үзээд байна. Тэгэхдээ тэгээд дахиад л орж ирж байгаа хүмүүс нь ийм сэтгэл зүрхтэй орж ирнэ гэвэл тэгээд л дарахаас өөр нөхцөлгүй болох байх. Тэгээд хугацааны эцэст та нар тэгж хэлж байсан шүү. Тэр хэлсний чинь хүрээнд бид нар ингэж зориод нэг ийм үр дүнд хүрчихлээ шүү гээд хэлэх үгтэй байгаарай л гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Заяабал гишүүний микрофоныг өгье.

Б.Заяабал: Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшээд, сонсголд орсон мэргэжлийн 2 хүндээ амжилт хүсье. Тэгээд та 2 минь үргэлжлүүлээд ажиллах байх гэж бодож байна. Тэгэхээр бид нар энэ санхүүгийн зах зээл гэдэг бол Монгол Улсад олигтой бас хөгжиж өгөхгүй байгаа л ийм салбар л даа. Тэгээд би бас өмнө нь асуух асуултдаа бас хэлж байсан. Энэ цэнхэр, ягаан тасалбар гэж гарч ирээд, ард иргэд ихэнх нь бараг хохироод дууссан. Цөөхөн хэд нь завшаад дууссан. Ингээд олигтой хөрөнгийн зах зээл санхүүгийн зах зээл тогтворжиж амжаагүй, хөгжиж амжаагүй байтал дахиад энэ крипто гэж юм гарч ирээд дахиад ингээд ард иргэдийн сэтгэлийг үймүүлээд хаячихсан. Гол нь санхүүгийн зах зээл бол хамгийн том, хамгийн хөгжүүлэх ёстой ийм шаардлагатай байгаад байгаа зах зээл байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр та бүхэн минь бас ард иргэдийн итгэлийг сэргээх, санхүүгийн зах зээлд оролцогчдын итгэлийг сэргээх, энэ зах зээлийг сэргээхтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санхүүгийн зохицуулы зохицуулах хорооны үйл ажиллагааг энэ чиглэл рүү хандуулах энэ том ажлыг бол та бүхэнд бол гүйцэтгэх ийм үүрэг ирж байна гэж ингэж ойлгож байна.

Тэгэхээр та бүхэн энэ үүргийг өөрсдөө ухамсарлаж байгаа байх. Тэгэхдээ энэ ухамсарлаж байгаа үүргийг нь биелүүлэхийн тулд бас манай Улсын Их Хурал бас энэ дээр онцгой анхаарах шаардлагатай байгаа гэж би бас үгээ хэлэх гэж байгаа юм.

Тэр нь энэ Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн ажиллах журам гэдгийг бид нар үнэхээр өөрчлөх цаг нь болчихсон юм байна гэдэг нь энэ зөвлөлийн журмыг уншихад бол харагдаж байгаа юм. Тэгээд би энэ дээр хэлэхэд бол энэ журмыг өөрчлөх зайлшгүй шаардлага байгаа юм гэдэг дээр 1 дүгээрт энэ Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийг ил тод, нээлттэй үйл ажиллагааг нь явуулдаг болгохын тулд энэ журам дээр гомдол маргааныг хүлээн аваад, шийдвэрлэж байгаа Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа, дээрээс нь санхүүгийн зах зээлийг боловсронгуй болгохдоо энэ хууль, эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой санал боловсруулах энэ үйл ажиллагаануудыг илүү тодорхой процесс ажиллагааг нь нээлттэй болгох чиглэлээр нэлээдгүй том ийм өөрчлөлтийг энэ журамд оруулж өгөхгүй бол болохгүй юм байна гэдэг нь тодорхой харагдаж байгаа. Гомдол маргааныг шийдэхтэй холбоотой асуудлыг санхүүгийн зах зээлд оролцогч Санхүүгийн зохицуулах хорооноос шийдвэр гаргаад, оролцогч этгээдүүд ерөнхийдөө гомдол гаргадаг. Гэтэл энэ эрх аваад үйл ажиллагаа явуулж байгаа, эрх аваад харилцаанд орж байгаа иргэдийн үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн цаана бол ард иргэдийн эрх ашиг гэж бас давхар явж байдаг. Тэгэхээр энэ гомдол маргааныг хянан хэлэлцэхдээ зөвхөн энэ Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн хүрээнд биш, нийтлэг бүх энэ эрх ашгуудыг хангасан чиглэлээр

Хяналтын зөвлөл бас үйл ажиллагаагаа явуулах ёстой юм болов уу гэж ингэж үзэж байгаа юм.

Хамтын шийдвэр гаргана гэдэгтэй холбоотойгоор бас ирц хүрэхгүй байна энэ тэр гэдэг шалтгаанаар бас удаа дараа хойшилдог гэж байгаа юм. Улиралд 1 удаа хуралдах ийм хуулийн хугацаатай, журмын хугацаатай. Зарим улиралд бол хэлэлцэх асуудал байхгүй гээд хуралддаггүй гэх мэтчилэн ийм зүйлүүд бас гардаг гэсэн ийм мэдээллүүд байгаад байгаа. Тэгэхээр энэ бүх асуудлуудыг нь илүү тодорхой тусгасан, илүү процесс ажиллагаануудыг нь нарийн журамлаж өгсөн, эрх, үүргийг чинь тодорхой болгож өгсөн ийм журмыг зайлшгүй гаргаж өгөх шаардлага байна гэж ингэж үзэж байгаа.

Хяналтын зөвлөл гээд 5 хүн байдаг. Ажлын алба гэж байдаггүй. Ажлын алба нь Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албыг үргэлжлүүлж ажиллуулдаг. Тэгэхээр ямар шийдвэр гарах вэ, мэдээж хорооны ажлын алба шийдвэр гаргахтай холбоотой бичиг баримтыг бэлтгэж байсан тэр хорооны ажлын алба эргээд гомдол маргааныг хянаж байгаа зөвлөлийн ажлын алба болж ажиллана гэхээр ямар шийдвэр гарах нь ойлгомжтой байгаа юм. Энэ дээр журамд ч өөрчлөлт оруулаад хараат бус хөндлөнгийн мэргэжлийн холбоодыг авах, дүгнэлт гаргуулах, тэр шийдвэр гаргах, гомдол хэлэлцэх асуудал дээр тэр шийдвэр гаргасан нөхдүүдийг оролцуулах, гомдол гаргасан нөхдүүдийг оролцуулах, ард иргэд нь цаана нь эрх ашиг нь яригдаж байгаа ард иргэдийн төлөөллийг оролцуулах гэх мэт .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Би бас товчхон хэдэн зүйл хэлчихье. Гишүүдийн хэлээд байгааг та нар сонсож байгаа байх. Өөрөөр хэлбэл энд сэтгэл гаргаж ажиллаарай л гэж хэлээд байна шүү дээ. Та нар чин сэтгэлээсээ ажиллаарай. Их Хурлаар ингээд энэ улсад байгаа энэ чинь парламентын засаглалтай орон гэж байгаа бол энэ улсад байгаа төрийн шийдвэр гаргах хамгийн дээд байгууллагаар та нар орж ирээд томилогдоод гарч байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол та нарын тэнд очоод гаргах шийдвэрийн далайц, цар хүрээ чинь тэр хэмжээгээр эндээс мандаттай очно гэдэг бол тэр хэмжээгээр л боломж байж байгаа.

Та хэдийн нэг хариулаад байгаа юм чинь бол зөв. Хуулийн хүрээнд ажиллана гэж байгаа чинь зөв. Гэхдээ гишүүдийн хэлж байгаа нэг юмыг энэ өнцгөөс нь та нар зөвөөр ойлгоорой. Хуулийн хүрээнд маш далайцтай ажиллах боломж байдаг. Жишээлбэл, сая Заяабал гишүүний ярьж байгаатай би яг санал нэгтэй байна. Энэ журам чинь бол үнэхээр болохгүй бөгөөд хоцрогдчихсон журам явж байна. Би лав тэгж харж байна. Тэгэхээр энэ журмаа бид нар ингээд өөрчлөхгүй бол болохгүй нь гэдэг юмаа энэ Их Хурлын гишүүд дээр аваад ороод ирэхэд энэ бүрэн эрх та нарт байгаа. Энэ чинь хуулийнхаа хүрээнд ажиллаж байгаа байхгүй юу. Тэгтэл энэ журмаа та нар өөрчлөхөд тэнд тоглоомын дүрмийг ямар хэмжээнд өөрчлөх нөөц бололцоо байна. Та нар тэр дотор очоод орлоо, тэр дотор байгаа аягүй бол энд байгаа гишүүд ч тэр болгон тэр лүү чинь анхаарч амжихгүй байгаа. Тэгэхээр та нарын тэнд очоод орох дотоод мэдээллийн түвшин энд байгаа гишүүдийнхээс хамаагүй өөр болчихно. Тэгээд тэрийгээ хараад ийм өөрчлөлтүүд хийхгүй бол болохгүй байна гэдэг зориг гаргаж орж ирнэ гэдэг чинь бол тэр сэтгэлээсээ ажиллаарай гэж хэлээд байгаа чинь энэ байгаа юм.

Би зүгээр гишүүддээ хандаад хэлэхэд энд чинь нэг ийм юм байгаа юм байна шүү. Энэ нөгөө хяналтын зөвлөлд чинь 5 хүн байх ёстой. Одоо Эдийн засгийн байнгын хорооноос 2, тэгээд тэнд ерөөсөө дарга нь 1 л хүн сууж байгаа юм байна. Эндээс 2 орохгүй бол нөгөөдүүл чинь тэнд 1 хүн жишээлбэл дутуу болоод л, ахиад л процессоороо 1 хүн орж ирэх тийм асуудал гарахаар юм байна. Тэгэхдээ ер нь бол бүтцийг нь гүйцээж өгөхгүй бол тэнд нэг хүний яг тэр дутагдал гарахаар юм байна.

2-т өмнө нь байсан 1 гишүүн нь аль хэдийн яг таны асуугаад байгаа зөв байхгүй юу. 2016 оноос хийж байсан хүн нь аль хэдийн хаяад явчихсан юм байна. Би одоо ингээд болсон гээд. Ингээд нөгөө хүн нь хаяад явчихсан. Одоо тэнд ерөөсөө угаасаа тэр хорооны дарга нь ганцхан хүн байж байгаа юм байна. 2016 оноос хурлаа хийгээгүй байж байгаа байгууллага байна шүү дээ энэ чинь. Тэгэхээр энэ дээр тэр ажиллах боломж нөхцөл нь бид нар бол нээрээ бодит байдал дээр энэ чинь маш олон иргэд. Үгүй ээ, та нар нэг юмаа зоригтой хариулж сурах хэрэгтэй. Юу гэвэл байна шүү дээ. Энд ингээд орж ирээд та нар яагаад цалингүй ажиллах гээд байгаа юм бэ гээд 1 дүгээрт та нар энд орж ирээд ажиллахад та нарын туршлага, энэ салбарын мэдээлэл, мэдлэг чинь хамаагүй өргөн болно. Дараа нь та нар энэ ажлаа цаг чинь дуусаад гараад явахад та нарын ур чадварын зах зээлийн үнэлгээ шал өөр болчихсон байна шүү дээ. Энийгээ ичихгүй шууд ярьдаг байх хэрэгтэй. Зах зээлийн эдийн засагт ажиллаж байгаа шүү дээ. Та нар энд ороод гарахад орсон хүнээсээ шал өөр хүн болчихсон. Зах зээл дээр хүлээн авагдана. Тэгэхээр тэнд бага зэргийн урамшуулал байхаас гадна бид туршлага авах гэж байгаа юм, илүү мэдлэгтэй, мэдээлэлтэй болох гэж байна, мэдлэгээ баяжуулах гэж байна гэж хэлэхэд ичих юм байхгүй шүү дээ. Энийг шууд хэлдэг байх хэрэгтэй. Тэгээд миний үг бол үүгээр дуусаж байна. Ингээд санал хураалтдаа орёе.

Нэр дэвшигч Чимэдийн Сайнбилэгийг Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

Нэр дэвшигч Соронзонболдын Халиунааг Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 69,2 хувиар санал дэмжигдлээ. Тэгээд бас Ганбат гишүүн дэмжсэн байна. Ганбат гишүүнийг дэмжсэн гэдгээр тэмдэглээрэй.

Тэгээд энд нөгөө түрүүний яг миний саяын ярьсан нөгөө гараад явчихсан хүнийг нь чөлөөлөх ёстой юм байна. Тэр санал хураалтыг гялс явуулчихъя.

Нэр дэвшигчид дэмжигдсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссан Жадамбаагийн Эрдэнэбилэгийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 76,9 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан хэлэлцсэн талаарх байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр танилцуулна.

Би түрүүн нэг юмыг бас хэлэхээ орхигдуулчихсан байна лээ. Энэ 2 дугаар асуудал дээр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд хүн танилцуулах ёстой байгаа. Тэгээд энэ 2 дугаар асуудлаар шүү. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Чуулгын нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг танилцуулна.

Ингээд энэ 2 дугаар асуудал дээр Баасанжаргал гишүүн түдгэлзсэн шүү. Ирцэд орсон байсан. Түдгэлзсэн. Тэгээд түдгэлзсэнээр энийг бүртгэж авч, хурлын тэмдэглэлд оруулаарай.

Ингээд Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөлөө. Хуралдаанд оролцсон гишүүддээ талархал илэрхийлье.

18.03 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ